



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2020 · 05 сар | Дугаар 18

ГАРЧИГ

- 2–3** Бодлогын нийтлэл
- 4** Зохицуулалтын мэдээ
- 5–6** Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нэг арга хэрэгсэл
- 6–7** Зээлийн гэрээний харилцаан дахь хууль хэрэглээний зарим асуудлууд
- 8–9** Финтек ба регтек
- 10–12** Судлаачийн индэр
- 13–14** Танилцуулга
- 15** Санхүүгийн боловсрол
- 16** Хөрөнгө, оруулагч үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах өргөдөл, гомдлын судалгаа
- 17** Компанийн ТУЗ-ийн нэг гишүүнийг сонгоход шаардагдах хамгийн бага саналын тоог тооцож болох аргачлал
- 18–21** Зах зээлийн мэдээ
- 22–23** Коронавирусын ойрхи дорнод ба төв азийн бүс нутгийн хөгжилд үзүүлж буй нөлөө
- 24** Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу–3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- ☎ +976-51-264444
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.mn
- 📍 Санхүүгийн зохицуулах хороо
- 📱 @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ХАРИЛЦААН ДАХЬ ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ АСУУДЛУУД

Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас хяналтын шатны иргэний шүүх хуралдааны тогтоолыг судалж, зээлийн гэрээний харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн практик, анхаарах зарим асуудлын талаар 2020 оны 4 дүгээр сарын 16–ны өдөр 01 дугаартай зөвлөмж гаргасан байна. Тус зөвлөмжид зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээний хууль хэрэглээтэй холбоотой дараах асуудлуудыг дурдсаныг тоймлон хүргэе.

Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль /цаашид БЭБХЭМХТТЗҮАТ хууль гэх/-ийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгосон зээлд хүү, хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцож зарим зохицуулалтын талаар.

а) Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1–т зааснаар банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ.

БЭБХЭМХТТЗҮАТ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1–т зааснаар зээлийн хүү нь зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцсон зээлдэгчийн хариу төлбөр буюу зээлийн үнэ юм. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээг заавал бичгээр хийх бөгөөд зээлийг хүүтэй олгосон бол гэрээнд зээлийн хүүгийн хэмжээг тодорхой тусгах нь Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.1–т заасантай нийцнэ.

Зээлийн гэрээнд хүүгийн хэмжээ тодорхойгүй эсхүл маргаантай байгаа тохиолдолд талууд гэрээгээр хүү тохирсон гэж үзэх эсэх, тохирсон бол хүүг ямар хэмжээтэй болохыг тогтоосны эцэст нэхэмжлэлийн энэ шаардлагын талаар үндэслэл бүхий дүгнэлт хийх нөхцөл бүрдэнэ.

Жишээ нь, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд бусдад зээл олгохдоо хүүгийн хэмжээг 2 байдлаар тогтоосон талаар зохигч маргаж хоёр шатны шүүх хүүгийн хэмжээг тодорхойлохдоо өөр өөр дүгнэлт хийсэн байв.

Үргэлжлэл 6–р нүүрт »

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙГ ДААТГАЛД ХАМРУУЛАХ НЬ САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЭГ АРГА ХЭРЭГСЭЛ

Иргэдийн хадгаламжийг даатгалд хамруулах системийг дэлхийн 2–р дайны дараа үеэс эхлэн улс орнууд санхүүгийн салбартаа нэвтрүүлж эхэлсэн бөгөөд өнөөгийн байдлаар дэлхийн 140 улс хадгаламжийн даатгалын системийг нэвтрүүлээд байна. Манай улсын хувьд 2013 онд банкны хадгаламжийн даатгалын системийг нэвтрүүлсэн. Энэ ажлыг цаашид өргөжүүлж хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)–ны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах асуудлын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын ахлах референт Д.Дашнямтай ярилцлаа.

ХЗХ–ны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах эрх зүйн зохицуулалтын талаар яриагаа эхлүүлэх үү?

Санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд зохицуулалтад хамаарах этгээдүүдэд хийх хяналт, зохицуулалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зах зээлийн цаашдын өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх сайн туршлага, арга хэрэгслийг нэвтрүүлэх цогц арга хэмжээ шаардагддаг. Улсын Их Хурлаас Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг 2011 онд баталснаар энэ салбар бие даасан хуультай болсон. ХЗХ–ны хадгаламж эзэмшигч гишүүдийн хадгаламжийн баталгааг хангах зохицуулалтыг уг хуулийн 16.7–д “Хадгаламж, зээлийн хоршоо гишүүдийнхээ хадгаламжийн баталгааг хангах үүрэгтэй”, 55.1–т “Хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийн хадгаламж даатгалтай байна. Хадгаламж, зээлийн хоршооны хадгаламжийн даатгалтай холбогдсон харилцааг хадгаламжийн даатгалын хуулиар зохицуулна” гэж тус тус заасан боловч хэрэгжээгүй.

Үргэлжлэл 5–р нүүрт »

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, үр чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХҮЧИН ЧАРМАЙЛТЫН ҮР ДҮН ГАРЧ БАЙНА



Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэнтэй саарал жагсаалтаас гарах ажлын явц ямар байгаа талаар ярилцлаа.

Монгол Улс ФАТФ-ын “Саарал жагсаалт”-аас гарахаар эрчимтэй ажиллаж эхэлсэн. Танай байгууллагын зүгээс энэ асуудалд хэрхэн анхаарал хандуулж байна вэ?

Өнгөрсөн оны аравдугаар сарын 18-нд манай улсыг стратегийн дутагдалтай орны жагсаалтад оруулсан. Ингэхдээ ФАТФ буюу олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагаас Монгол Улсад зургаан үүрэг даалгавар өгсөн. Үүнээс манай Санхүүгийн зохицуулах хороонд хамааралтай хоёр асуудал байсны нэг нь санхүүгийн болон санхүүгийн бус салбаруудын зохицуулалтыг сайжруулах үүргийг бид хүлээсэн. Үүнтэй холбоотойгоор Терроризмтой тэмцэх тухай хуульд өнгөрсөн оны аравдугаар сард өөрчлөлт оруулснаар Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болгон өөрчилж, баталсан. Ингэснээр Хорооны чиг үүрэгт санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах үүрэг хүлээсэн гэсэн үг. Ер нь санхүүгийн зохицуулагч байгууллага нь санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээг хянан зохицуулдаг тохиолдол ховор. Гэхдээ энэ салбарыг хариуцаад зохицуулах байгууллага Монгол Улсад Хорооноос өөр алга гэж үзээд өнгөрсөн оны тавдугаар сард манай чиг үүрэгт

дээрх хоёр салбарыг шинээр нэмж өгсөн. Мэдээж бидний хувьд таатай хүлээж аваагүй. Учир нь санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг зохицуулах нь маш олон эрсдэлийг дагуулна гэж үзсэн. Тухайлбал, шинэ салбарыг зохицуулах чиглэл авахын хэрээр боловсон хүчин, хүний нөөцөөс эхлээд санхүүгийн эх үүсвэр нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байдаг. Нөгөө талд, үндсэн ажил буюу банкнаас бусад санхүүгийн салбарын зохицуулалтыг сулруулах эрсдэлтэй талаар байр сууриа илэрхийлж байсан. Гэхдээ Засгийн газрын зүгээс дээрх хоёр салбарыг Хорооноос өөр зохицуулах төрийн байгууллага үгүй гэж үзсэн учраас манайд өгсөн. Аливаа төрийн зохицуулалтыг зайлшгүй гэж үзвэл тусгай зөвшөөрлийн хүрээнд авч үзэх учиртай. Ингэснээр тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тавихаас гадна зохицуулалт, хяналтаа хэрэгжүүлэх болсноор тухайн үйлчилгээ, үйл ажиллагаанд гарч болзошгүй зөрчил дутагдлыг арилгах талд ажиллаж эхэлнэ гэсэн үг. Эхний ээлжинд энэ хоёр салбарыг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг нь бүрдүүлсэн.

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч гэдэгт ямар төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулан ойлгох ёстой вэ?

Манай Хорооны чиг үүрэгт нэмэгдсэн 2 салбараас гадна зөвлөгөө үзүүлдэг хуульч, нотариатч, нягтлан бодогчид багтдаг. Эдгээрийг олон улсад санхүүгийн салбарт хууль бусаар мөнгө угаах, түүнтэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх эрсдэлтэй гэж үздэг. Тухайлбал, хуульчдын хувьд хуулийн хийдэл ашиглах, тойруулах алхам хийх зөвлөгөө өгөх, нотариатчдын хувьд аливаа хөрөнгө мөнгөний гарал үүслийг хянаж тамга дардаг учраас үгсэн хуйвалдах зэрэг үйлдэл хийхгүй гэх баталгаагүй. Тийм учраас ийм төрлийн үйлчилгээ эрхлэгчдийг төрөөс зохицуулах шаардлагатай гэж үзээд тус тусынх нь салбарт хариуцуулсан. Жишээлбэл, хуульч хуульчдын холбоонд, нотариатчдыг нотариатчдын танхим, нягтлан бодогчдыг мэргэшсэн нягтлан бодогчдын институт зэрэг өөрийгөө зохицуулагч байгууллагуудад харьяалуулах гэх мэтээр. Үүний цаана мэдээж төрийн байгууллага буюу ХЗДХЯ, Сангийн яам зэрэг байгууллага ерөнхийд нь хариуцна.

Хорооноос тусгай зөвшөөрөл олгож эхэлснээр мэдээж Монгол Улс “Саарал жагсаалт”-аас

гарах нөхцөл бүрдэнэ. Нөгөө талдаа иргэдэд ямар давуу тал бий болох вэ? Дур зоргын байдалтай аливаа үйл ажиллагааны цаана иргэд хохирч үлддэг шүү дээ?

Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулна гэдэг нь мэргэжлийн болно л гэсэн үг. Үүний цаана хэрэглэгчдийн эрх ашгийг төр хамгаалж буй нэг хэлбэр. Өмнө нь жишээлбэл, төр зохицуулдаггүй, хянадаггүй учраас хэн нэгэн хохирлоо гэхэд хаана, хэнд хандахаа мэддэггүй байлаа. Одоо энэ асуудал тодорхой болж, эрх ашиг нь зөрчигдсэн, хохирсон гэж үзвэл Хороонд хандаж, эрх ашгаа хамгаалуулах боломж бүрдсэн.

Төрийн ямар нэгэн зохицуулалтгүй, дур зоргын байдалтай байсан хоёр салбарыг тусгай зөвшөөрөлтэй болгоно гэхээр мэдээж таатай хүлээж авахгүй байх. Энэ төрлийн үйлчилгээ эрхлэгчид хэрхэн хүлээн авч байна вэ?

Хорооны зүгээс эхний ээлжинд мэдээллээ гаргаж, энэ төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа бол тусгай зөвшөөрөл авах шаардлагатай болсон талаар мэдэгдсэн. Үл хөдлөх эд хөрөнгө болон үнэт металлын арилжаа эрхлэгчдийн холбоо, нийгэмлэгүүд болон аж ахуйн нэгжтэй тус бүрчлэн уулзаж мэдээлэл хүргэсэн. Төрийн бүх байгууллагаас ч энэ талаар санал авсан. Холбогдох хэлэлцүүлгийг ч зохион байгууллаа. Энэ бүхнээс үзэхэд таны хэлсэнчлэн хүмүүс таатай хүлээн авахгүй нь илт байсан. Олон жил өөрийн дураар явж ирсэн учраас дургүй байсан ч бид ойлгуулсан. Төрийн хяналтад орсноор тухайн салбарын хөгжилд тустай, нөгөө талаас Монгол Улсын нэр хүндэд маш том нөлөө үзүүлнэ гэдгийг хэлсэн. "Саарал жагсаалт"-аас гарахын тулд та бүхний эрхэлдэг үйл ажиллагааг зайлшгүй төрийн хяналтад авах шаардлагатай гэдгийг хэлж, ярьсан. Үүнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа маш чухал гэдгийг хүмүүс ойлгосон. Үүний тулд бид маш олон удаагийн сургалт, уулзалтыг зохион байгуулсан. Энэ бол зөвхөн Хорооноос хүсэж хийгээд байгаа ажил бус, Монголын ард түмний нийтлэг эрх ашгийн үүднээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ гэдгийг тухайн салбарынхан маань ойлгосон гэдэгт итгэлтэй байна.

Хороо тодорхой ямар ажлыг хийж гүйцэтгээд байна вэ? Тусгай зөвшөөрлийг олгох явц ямар байна вэ?

2020 оны нэгдүгээр сарын 17-ны өдрийн УИХ-аар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг

тусгай зөвшөөрөлтэй эрхлэхээр тусгаж баталгаажуулсан. Захиргааны ерөнхий хуулийн дагуу аливаа зохицуулалтыг хийх гэж байгаа бол холбогдох хуульдаа заавал нарийвчилсан өөрчлөлт оруулсан байх шаардлагатай байдаг. Энэ хоёр салбар өмнө нь ямар ч хяналтгүй явж ирсэн учраас хууль эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн нь бидний хийсэн хамгийн гол буюу чухал эхлэл болсон.

Шинээр тусгай зөвшөөрөл олгох хоёр салбартай холбогдох дүрэм, журмыг баталж, мөрдүүлж эхэлсэн. Ингээд хууль эрх зүйн орчныг бий болгосноор иргэн, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн. Өнөөдрийн байдлаар Хороонд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар 167 этгээд хандсанаас 61, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар 108 этгээд хандсанаас 38 этгээдэд тусгай зөвшөөрөл олгоод байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн болон үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн салбарт ямар нэгэн хяналт шалгалт шаардлагатай гэдгийг хэзээнээс, хэрхэн дүгнэсэн юм бэ? "Саарал жагсаалт"-д орсноор энэ салбарт төрийн зохицуулалт хэрэгтэй гэдгийг олж харсан хэрэг үү? Эсвэл төр шат дараатайгаар арга хэмжээ авсаар ирсэн юм уу?

Монгол Улс 2016 онд анх удаа Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийсэн байдаг. Түүгээр эрсдэлтэй салбаруудыг тодорхойлоход банктэй зэрэгцээд үл хөдлөх эд хөрөнгийн салбар хамгийн өндөр эрсдэлтэйд тооцогдсон. Нөгөө талаас ФАТФ-аас тавьж буй бүх шаардлагад үл хөдлөх эд хөрөнгө болон үнэт металл, үнэт чулууны арилжааны үйлчилгээ, үйл ажиллагаанд мөнгө угаах, улмаар терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр гэж тодорхойлоод байгаа юм. Мөн ФАТФ-ын стандартаар энэ хоёр үйлчилгээ, үйл ажиллагааг төрийн зохицуулалтад байх ёстой гэж үздэг. Нөгөө талаас, мөнгө угаах гэдэгт авлига, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх зэрэг олон харилцаа багтдаг. Тиймээс энэ харилцаанд оролцогчдыг олж илрүүлэх, хязгаарлах, хууль бус харилцааг төрийн хяналтаар зохицуулах гэдэг үүргийг олон улсаас өгөөд байгаа юм. Үүнийг олон улсаас тавьж буй стандартын шаардлага гэж ойлгох хэрэгтэй.

Дураараа, хяналтгүй байсан үйлчилгээ, үйл ажиллагааг төрийн хяналтад оруулчихлаа. Зохицуулалтгүй байсан салбарыг зохицуулаад эхэлж байгаа нь төр хийх ажилгүйдээ биш шүү дээ. Хамгийн гол нь үүнийг дагаад нийгмийн маш том бодлого явдаг. Ингэснээр

салбарын хөгжил олон улсын сайн жишигтэй хөл нийлүүлэн алхах, үйлчилгээний соёл нь нийтлэг сайн зарчимд хүрнэ гэж харж байна. Нөгөө талаас, иргэдэд мэргэжлийн үйлчилгээ авах бололцоог бий болгож, хөндөгдсөн эрх ашгаа хамгаалуулах зохицуулалт бий болсон.

Хорооноос ФАТФ-ын жагсаалтаас гарах чиглэлд хэрэгжүүлсэн ажлын талаар товч ярилцъя?

Энэ оны нэгдүгээр сарын 20-нд Бээжин хотноо болсон Ази, Номхон далайн хамтарсан бүлэг (АНДХБ)-ийн хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулахаар Монгол Улс хийсэн анхны ажлаа хамгаалсан. Монгол Улс зургаан ажлын даалгавар авснаас гурвыг нь хамгаалсан. Мөн хоёрдугаар сарын 20-нд Парис хотод болсон ФАТФ-ын хурлын үеэр ч манай улсаас авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг өндөрөөр үнэлсэн. Маш богино хугацаанд өндөр үзүүлэлттэй ажилласан гэж дүгнэсэн. Тиймээс бидний хувьд энэ үнэлэмжээ алдахгүй урагшлах, улмаар стратегийн дутагдалтай орны жагсаалтаас түргэн хугацаанд гарахын тулд бүхий л хүч чадал, нөөцөө ашиглан ажиллаж байна. Үндсэндээ Хороотой хамааралтай санхүүгийн салбар буюу үнэт цаас, даатгал, ББСБ, ХЗХ-нд мөнгө угаах, терроризмтой тэмцэх ажил сайн явахаас гадна үр дүнгээ өгч байна гэж дүгнэсэн. Харин Хорооны чиг үүрэгт шинээр нэмэгдсэн үл хөдлөх, үнэт металлын салбарын зохицуулалт хараахан болоогүй байна гэж үзсэн. Үүнээс хойш Хороо дээрх салбарт үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах шаардлага, хяналт тавих, зөрчил дутагдал гаргавал хэрхэн хариуцлага тооцох вэ гэдгийг тодорхой болгож төрийн хяналтад авч, тусгай зөвшөөрөл олгодог тогтолцоог бүрдүүлээд байна. Үүний дүнд энэ 5 дугаар сарын 11-ний өдөр Монгол Улс АНДХБ-т үлдсэн гурван ажлын даалгаврын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар танилцуулж, тайлангаа хамгаалахад хувь нэмрээ оруулсан гэж үзэж байна.

Тайлангаа хамгаалсан ч үнэлгээний баг ирэхээр бүдэрчих юм биш биз дээ?

Энэ бол бодит эрсдэл. Тийм учраас шат шатандаа үүнд маш сайн анхаарах хэрэгтэй. Гэхдээ бид ийм эрсдэлт нөхцөлийг харж байгаа учраас тодорхой хийх ажлын төлөвлөгөөг гаргасан байгаа. Хэдийгээр төрийн байгууллагууд маш сайн хичээж байгаа ч үүнийг бодит ажил болгоход аж ахуйн нэгжүүд маш чухал нөлөөтэй гэдгийг ойлгох хэрэгтэй байгаа юм. Төр, хувийн хэвшлийн түншлэл маш сайн уялдаа холбоотой байж, төрөөс гаргасан шийдвэрийг аж ахуйн нэгж нь, иргэн нь сайн гүйцэтгэдэг цагт бидэнд айх зүйл байхгүй.

Ярилцсанд баярлалаа.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-аас Монгол Улсад суугаа суурин төлөөлөгч Руфат Алимарданов нар Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслүүдийг хамтран хэрэгжүүлэхээр “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр цахим хэлбэрээр үзэглэлээ.

Дэлхийн банкны бүлгийн гишүүн ОУСК нь хөгжиж буй орнуудын хувийн хэвшлийн тогтвортой хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулах болон хүн амын амьжиргааг сайжруулах зорилго бүхий олон улсын санхүүгийн байгууллага юм.

Ногоон санхүүжилтийг хөгжүүлэх санамж бичгийн хүрээнд Монгол Улсад ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, ялангуяа ногоон бонд гаргахад чиглэсэн заавар, зөвлөмжийг боловсруулах, банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм болон засаглалын шаардлагыг нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй төсөл, бизнесийн үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийг нэмэгдүүлэх, уур амьсгалтай холбоотой эрсдэлийг үнэлэх, бодлого боловсруулах үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэх юм.

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх санамж бичгийн хүрээнд Монгол Улсад өртгийн буюу нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх, факторингийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн талаар мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл авах боломжийг нэмэгдүүлэх юм.

Эдгээр төслүүдийг хэрэгжүүлсний үр дүнд Монгол улсын санхүүгийн салбарт байгаль орчинд ээлтэй ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, банк бус санхүүгийн байгууллагууд хөдлөх хөрөнгө барьцаалсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх чадавх дээшилж, тэдгээрийн зээлийн багц төрөлжих, жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгох санхүүжилт нэмэгдэх, санхүүгийн хүртээмжийг сайжирч, нийлүүлэлтийн сүлжээний үйл ажиллагаа хөгжих боломж бүрдэх юм.

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ЗУУЧЛАГЧ КОМПАНИУД ЗОХИЦУУЛАЛТТАЙ БОЛЖ ЭХЭЛЛЭЭ



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагын дагуу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх байгууллагын хүний нөөц, ажлын байр, тоног төхөөрөмж, санхүүгийн чадамж болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зарчим, нөхцөл шаардлагыг тухайн салбарт оролцогчдын онцлогт нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг баталсан. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн компаниудаас хууль тогтоомжийн нөхцөл шаардлагыг хангасан анхдагч 8 хуулийн этгээдэд Хорооны 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 8 дугаар хуралдаанаар тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг гаргаж, 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдөр тусгай зөвшөөрлийн гэрчилгээг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан болон бусад удирдлагууд гардууллаа.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС СЭРЭМЖЛҮҮЛЖ БАЙНА

Монгол Улсын 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс өмнө төрсөн иргэдэд эзэмшүүлсэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцаатай холбоотой олон нийтийн цахим сүлжээнд худал ташаа мэдээлэл, сурталчилгаа тавигдах боллоо.

Тухайлбал фэйсбүүк олон нийтийн сүлжээнд “1072 хувьцаа авна”, “1072 хувьцаа бэлэн мөнгөөр авна”, “1072 хувьцаа худалдаж авна, данс нээнэ” гэх зэрэг зар мэдээлэл нь иргэд, олон нийтийг залилан мэхэлж болзошгүй гэмт хэргийн шинжтэй, зөвхөн пэйж хуудсаа олон хүний хандалттай болгох гэсэн зорилготой үйлдэл гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолын хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн иргэдэд эзэмшүүлсэн хувьцаа нь захиран зарцуулахгүй байх нөхцөлтэй буюу арилжаалагдах, бусдад шилжүүлэх боломжгүй бөгөөд Хорооны үнэт цаасны зах зээлд тусгай зөвшөөрөлтэй, зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д хандан 1,072 хувьцаатай холбоотой мэдээ, мэдээллийг авах боломжтой.

Иймд иргэд та бүхэн 1,072 хувьцаатай холбоотой цахим сүлжээн дэх албан бус мэдээлэл, сурталчилгаанд хууртагдахгүй байх, бусдад залилан мэхлүүлэхгүй байхыг сэрэмжлүүлж байна.

БАЙР СУУРЬ

» Эхлэл 1-р нүүрт

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙГ ДААТГАЛД ХАМРУУЛАХ НЬ САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЭГ АРГА ХЭРЭГСЭЛ

Хэрэгжээгүй шалтгааных нь талаар нэмэлт тайлбар өгнө үү.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд хадгаламжийн даатгалыг хэрэгжүүлэх арга механизмыг тодорхойгүй үлдээсэн. Санхүүгийн зохицуулах хорооноос Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийг даатгалд хамруулах зорилгоор 2012 онд Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ажлын хэсэгт хүргүүлж байсан боловч Улсын Их Хурлын 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд ХЗХ-ны хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хадгаламжийг хамгаалах зохицуулалт тусгагдаагүй. Мөн 2015, 2019 онд уг асуудлыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулсан боловч дэмжлэг аваагүй. Олон улсын туршлагаас харахад банк болон ХЗХ-ны хадгаламж хамгааллын тогтолцоо нь ойролцоо зохицуулалттай байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хадгаламжийн дүн, өсөлт, төвлөрөл зэрэг үзүүлэлтээс мэдээлэл өгнө үү.

2020 оны эхний улирлын байдлаар нийт 159 тэрбум төгрөгийн хадгаламжийг энэ зах зээлд татан төвлөрүүлсэн байна. Энэ үзүүлэлт өнгөрсөн оны мөн үеэс 5.4 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд банкны салбарын нийт хадгаламжийн 1.2 хувийг эзэлж байна. 2013–2019 оны хооронд салбарын хэмжээнд мөнгөн хадгаламжийн дүн 36.1 хувиар өссөн.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 1 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 14 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 137.6 тэрбум төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 86.6 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 14 ХЗХ байна.

ХЗХ-дын гишүүдийн хадгаламжийг 2018 оны жилийн эцсийн байдлаар судалж үзэхэд нийт гишүүдийн 92 хувь нь 5 сая хүртэлх төгрөгийн хадгаламжтай, 94 хувь нь 10 сая хүртэлх төгрөгийн хадгаламжтай гэсэн тооцоо гарсан.

Хадгаламжийн даатгалын тогтолцооны тухайд олон улсын туршлага ямархуу зохицуулалттай байдаг вэ?

Өнөө цагт банкнаас гадна ХЗХ-г мөн хамруулсан хадгаламжийн баталгааны тогтолцоо олон оронд мөрдөгдөж байгаа, энэ цуваа үргэлжилсээр байгаа нь энэ төрлийн хамгаалалт дэлхий дахинд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд дөхөмтэй болохыг гэрчилж байна.

ХЗХ-ны зах зээлийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх АХБ-ны төсөл 2016 оноос хэрэгжиж, хадгаламжийн даатгалын асуудал дээр зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. Хадгаламжийн даатгалын асуудалтай холбоотойгоор хийх хууль эрх зүйн орчны өөрчлөлт, хураамжийн тооцоолол, сангийн удирдлага зэрэг асуудлууд дээр төслийн зөвлөхүүд зөвлөж, саналаа өгч байгаа. Даатгалын хураамжийн хувьд эхний ээлжинд “paybox” буюу хадгаламжийн тодорхой хувийг даатгах нь сангийн хүрэлцээ болон тогтвортой үйл ажиллагаанд ач холбогдолтой. Сангийн хэмжээ хангалттай хэмжээнд хүрч ХЗХ-дын эрсдэлийн түвшин багассан үед аажмаар хадгаламжийг бүхэлд нь даатгадаг системд шилжих нь эрсдэл багатай гэж үзэж байгаа.

Олон улсад хадгаламжийн даатгалын байгууллагууд нь төрийн буюу бие даасан эсхүл хяналт шалгалтын байгууллагатай хамтарсан, хувийн буюу ихэвчлэн нэгдэл холбоо, мөн төрийн болон хувийн хамтарсан буюу төрийн өмчит, төрөөс санхүүжилттэй компани зэрэг олон хэлбэрээр байдаг. ХЗХ-ны хувьд хадгаламжийн даатгал нь ихэвчлэн

албан журмын байдаг бөгөөд хэрэв ХЗХ нь хувийн хэвшлийн хадгаламжийн компанид даатгуулах бол гишүүдээ мэдэгдэж тэдгээрийн саналын дагуу шийдвэрлэдэг. Хувийн хадгаламжийн даатгалын системийн гол дутагдал нь сайн дурын учраас даатгалд хамрагдсан байгууллагуудын заавал дагаж мөрдөх тогтолцооны зарчмуудыг мөрдлөг болгодоггүй. Цаашид олон улсад хадгаламжийн даатгалын тогтолцоог албан журмын байлгах чиг хандлагатай байна. ХЗХ нь банкны систем болтлоо хөгжсөн оронд ХЗХ, банкны даатгал нь нэг хуулиар зохицуулагддаг бол зарим улсад ХЗХ-ны бие даасан хадгаламжийн даатгалын хуулиар зохицуулагддаг. Сүүлийн үеийн чиг хандлага хадгаламжийн даатгалын байгууллага нь хамгаалалт хамгийн их шаардлагатай гэсэн хадгаламж татдаг бүх санхүүгийн байгууллагуудыг гишүүнээр элсүүлэхэд чиглээд байна.

Жишээ болох улс орнуудыг нэрлэвэл илүү тодорхой болох байх?

Жишээ нь, АНУ болон Кени дэх хадгаламжийн даатгалын байгууллагыг хяналт шалгалтын байгууллагын удирдлаган дор үүсгэн байгуулсан байдаг. АНУ-ын ХЗХ-ны үндэсний даатгалын сангийн үйл ажиллагаа нь ХЗХ-доос бүрэн санхүүжих хяналтын байгууллага удирдах ба сангийн үйл ажиллагааг АНУ-ын Эрдэнэсийн сангаас дэмжин ажиллаж байна. Кени улсын тухайд, хадгаламжийн даатгалын сан нь хадгаламж, зээлийн нэгдсэн холбоо (SACCO)-ны хандиваар санхүүжиж, салбарын төлөөлөл багтсан зөвлөлөөр удирдуулах хэдий ч төлөөллүүдийг төрийн эрх бүхий байгууллагуудын олонхийн саналаар сонгодог. Их Британи болон Ирланд улсын хувьд төрийн санхүүжилттэй хадгаламжийн даатгалын тогтолцооны хүрээнд хадгаламжийн даатгалын сан нь ХЗХ-дыг гишүүнчлэлээр элсүүлнэ. Ирланд улсын тухайд, саяхныг хүртэл ХЗХ-дын

хамгаалалтын тогтолцоог тэдгээрийг нэгтгэсэн холбоо буюу нийгэмлэг нь удирдаж байжээ. Герман, Солонгос, Бразил зэрэг орнуудын хувьд хадгаламжийн даатгалын тогтолцоог эсрэгээрээ ХЗХ-дын нийгэмлэг буюу холбоо эсхүл хадгаламжийн даатгалд тусгайлан зориулагдсан ашгийн бус байгууллагууд удирддаг байна.

Хадгаламжийн даатгалын систем ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийг хамарснаар ХЗХ-ны гишүүдийн хувьд, цаашлаад санхүүгийн салбарт гарах өөрчлөлт, ач холбогдол ямар байх вэ?

Олон улсын туршлагаас үзэхэд санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор ХЗХ-ны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулж, иргэдийн санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. Юун түүрүүнд ямарваа нэгэн ХЗХ санхүүгийн чадамжгүй боллоо гэхэд хадгаламж эзэмшигчдийг хамгаалах тогтолцоо бүрдэнэ гэсэн үг. Мөн ХЗХ-ны гишүүдийн мөнгөн хадгаламжийг даатгалд хамруулснаар ХЗХ-

дод тавих хяналтын систем боловсронгуй болох, ил тод байдал дээшлэх, цаашлаад тогтвортой хөгжлийг хангахад чухал ач холбогдолтойгоос гадна гишүүдийн хадгаламж даатгагдсанаар хадгаламжийн хэмжээ нэмэгдэх, улмаар санхүүгийн хүртээмж нэмэгдэж, санхүүгийн салбарын олон тулгуурт тогтолцоог хөгжүүлэхэд чухал нөлөөтэй юм. Гэхдээ иргэд, хадгаламж эзэмшигчдийн итгэлийг нэмэгдүүлж, улмаар хадгаламжийг нэмэгдүүлэх энэ ажил нь өөрөө иргэдийн санхүүгийн боловсрол, энэ чиглэлийн мэдлэг мэдээлэлтэй нягт холбоотой.

ХЗХ-ны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулахад ямар бэлтгэл ажил хийх шаардлагатай вэ?

ХЗХ-ны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулахын өмнө тогтворжилтын сан хэрэгтэй, мөн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжинэ. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжих нь хадгаламжийн даатгалын

болон тогтворжилтын сангийн үйлчилгээг нэвтрүүлэх, салбарын дэд бүтцийг бий болгох суурь болно. Эдгээр хамгаалалтын тогтолцоог нэвтрүүлж нэгдсэн дэд бүтцийг бий болгоход зайлшгүй хууль эрх зүйн орчныг өөрчлөх шаардлага тулгарч байна.

Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т ХЗХ-ны салбарын хөгжлийн 4 зорилгыг дэвшүүлсний дотор салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, чадавхжуулахад чиглэсэн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, салбарын нэгдсэн дэд бүтцийг бий болгох ажил тусгагдсан. Энэхүү ажлууд Санхүүгийн зохицуулах хорооны 2018–2021 оны стратеги төлөвлөгөөнд ч мөн туссан. Санхүүгийн зохицуулах хорооноос Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа бөгөөд хадгаламжийн даатгалын асуудлыг шинэчилсэн найруулгын төсөлд нарийвчлан тусгахаар ажиллаж байна.

Ярилцсанд баярлалаа.

» Эхлэл 1-р нүүрт

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ХАРИЛЦААН ДАХЬ ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ АСУУДЛУУД

Улсын Дээд шүүхийн 2018 оны 001/ХТ2018/01164 дүгээр тогтоолоор, “...зээлийн гэрээнд хүүг ...4.5 хувь, хэрэв хүүг хугацаандаа төлвөл 3.5 хувь болгон бууруулахаар өөрөөр тогтоосон...”-ыг талуудын мэтгэлцээнийг үндэслэн нэхэмжлэгчийн хувьд зээлийн үйл ажиллагааг тогтмол эрхэлж, урьдчилан тогтоосон нөхцөл бүхий гэрээ байгуулсан нь Иргэний хуулийн 200 дугаар зүйлийн 200.1-т заасан стандарт нөхцөл бүхий гэрээ гэж үзэн, зээлдэгчид ашигтайгаар тайлбарлаж, зээлийн хүүгийн тооцооллыг багасгаж өөрчлөх нь Иргэний хуулийн 201 дүгээр зүйлийн 201.1-т нийцнэ. гэсэн шүүхийн дүгнэлтийг зөв гэж үзжээ.

Зээлийн хүүг гэрээнд өөр өөр нөхцөлөөр тусгаж болох ч тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зээлийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд нөгөө талдаа санал болгож байгаа хүүгийн хэмжээг гэрээний хугацаанд өөрчилж байхаар тохиролцсон үндэслэл, шалтгаан, энэ нь хуулиар тодорхойлоогүй буюу хуулийн заалтыг тодотгосон журам, байнга хэрэглэгдэх, урьдчилан тогтоосон нөхцөл байгаа эсэхийг анхаарах шаардлагатай.

б) Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь

төлөөгүй бөгөөд гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй гэж Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 453.1-т заажээ. БЭБХЭМХТТЗҮАТ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 25 дугаар зүйлийн 25.2-т заасан зохицуулалтаас үзвэл хэтэрсэн хугацааны хүүг, зээлийн гэрээний хугацаа дууссанаас хойш үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл төлөх ба хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн хэмжээ нь зээлийн гэрээгээр тохирсон үндсэн хүүгийн хэмжээнээс хэтрэх ёсгүй байна. Зээлийн гэрээний хугацаанд төлөгдвөл зохих хүү нь гэрээний үндсэн үүрэгт, хэтэрсэн хугацааны хүү нь үүргээ зохих ёсоор биелүүлээгүй хугацаа хэтрүүлснээс үүсэх нэмэлт үүрэгт тус тус хамаардаг тул эдгээрийн шаардах эрхийн хууль зүйн үндэслэл өөр байдгийг анхаарч гэрээний хугацаан дахь төлөгдөөгүй хүү болон хэтэрсэн хугацааны хүү тус тус хэд болохыг ялгамжтай тодорхойлох шаардлагатай.

Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.2-т зааснаар зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж

болно. Иргэний хуулийн 44, 45, 46 дугаар бүлэг, БЭБХЭМХТТЗҮАТ хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 53 дугаар тогтоолд Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.2-т заасан нэмэгдүүлсэн хүү гэж зээлдэгч авсан зээлээ гэрээнд заасан хугацаандаа буцааж төлөөгүй тохиолдолд зээлдэгчээр үндсэн хүүн дээр нэмж төлүүлэхээр тогтоож, гэрээгээр тодорхойлсон хариуцлагын хэлбэрийг хэлэх бөгөөд “үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлнө” гэдгийг “зээлдэгч нь банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй тохиолдолд төлөгдөөгүй байгаа зээлд ноогдох үндсэн хүүгийн хорин хувиас хэтрүүлэхгүй нэмэгдүүлсэн хүү тооцож төлнө гэж ойлгоно” гэсэн байна. Эдгээрээс үзвэл нэмэгдүүлсэн хүү төлөх эсэхийг талууд зээлийн гэрээгээр тохиролцсон байх, уг тохиролцоо хуулийн агуулгад нийцсэн байх нь нэмэгдүүлсэн хүү шаардах эрх үүсгэнэ гэж ойлгоно.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл

ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “зээлийн хүүгийн хэмжээг бодох аргачлалыг Монгол банк батална” гэж заасан ба тус банкны ерөнхийлөгчийн 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А-203 тоот тушаалаар батлагдсан “банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам” хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус журмын 1.3.9-д “гэрээнд заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг эргүүлэн төлөөгүй тохиолдолд Иргэний хуульд заасан хувиас хэтрэхгүй хувь хэмжээгээр үндсэн хүүг нэмэгдүүлж тооцсон хүүгийн хувь хэмжээг “нэмэгдүүлсэн хүү” гэж тодорхойлж, 1-р хавсралтын нэгийн 4-т нэмэгдүүлсэн хүү тооцох аргачлалыг томъёогоор тооцоолсныг судлах шаардлагатай.

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР

Зээлийн гэрээний дагуу зээлдэгчийн хүлээх үүргийн хэмжээг тогтоохын тулд тухайн гэрээний хугацаа, төлбөр хийсэн огноо тус бүрийг харгалзан үзэхээс гадна төлөгдсөн төлбөр чухамхүү гэрээний аль үүрэгт хамаарахыг тодорхой болгох шаардлагатай. Зээлдэгчийн үүрэг гүйцэтгэх хугацааг зөв тодорхойлоогүйгээс төлвөл зохих төлбөрийн хэмжээг алдаатай тооцсон тохиолдол гардаг.

Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1, БЭБХЭМХТТЗҮАТ хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх зохицуулалтаас үзвэл банк, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээ хугацаатай байхыг шаардсан байна. Бусад зээлийн гэрээг хугацаатай болон хугацаагүй байгуулж болохыг Иргэний хуулийн 208, 283 дугаар зүйлийн 283.1-т заажээ. Гэрээнд ерөнхий хугацаанаас гадна үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх хугацааг зааж болно. Зээлийн гэрээ хугацаатай бол уг хугацаа өнгөрмөгц зээлийг буцаан төлөхийг шаардах эрх үүснэ.

Зээлийн гэрээгээр зээлийг буцаан төлөх хугацаа тогтоогоогүй бол зээлдүүлэгчийн шаардсанаар түүнийг буцаан төлөх бөгөөд ийнхүү шаардсанаас хойш нэг сарын дотор зээлдэгч үүргээ биелүүлнэ.

Гэрээний талууд тохиролцож гэрээний хугацааг сунгах эрхтэй. Хугацааг сунгахдаа үндсэн гэрээний хугацаа дуусахаас өмнө сунгасан байхыг хууль шаарддаг боловч талууд хожим нь хүсэл зоригоо бүрэн илэрхийлж гэрээний хугацааг сунгасан, энэ талаар зохигч маргахгүй бол шүүх гэрээг сунгасан гэж үзэх нь талуудын зарчимд нийцнэ. Хугацаа сунгах тохиолдолд хугацаа дууссан үеэс шинэ хугацааг тоолно.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ТАЛААР

Иргэний хуулийн 458 дугаар зүйлийн 458.1-т заасан батлан даалтын гэрээгээр батлан даагч нь үүрэг гүйцэтгэгч өөрийн үүргийг гүйцэтгэж чадахгүй бол өөрөө хариуцах үүрэг хүлээнэ. Батлан даалтын гэрээгээр, батлан даагчийн хүлээсэн үүрэг нь үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэгт хамаарах бөгөөд батлан даалтын гэрээгээр батлан даагч нь үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс нөхөх хариуцлага хүлээхийг Иргэний хуулийн 460 дугаар зүйлийн 460.1-т заасан байна. Харин үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг батлан даагч нь үүрэг гүйцэтгэгчтэй хамтран хариуцахаар гэрээнд заасан бол үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл үүргээ гүйцэтгэж чадахгүй нь илт тодорхой байвал үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэхийг батлан даагчаас шаардах эрхтэй болох нь Иргэний хуулийн 460 дугаар зүйлийн 460.2-т туссан байна. Батлан даагч нь нөхөх хариуцлагыг, эсхүл хамтран үүрэг хүлээхийг талуудын хооронд байгуулагдсан гэрээнд хэрхэн заасныг анхаарах нь чухал. Түүнчлэн Иргэний хуулийн 460.4-т зааснаар батлан даагч нь батлан даалтын гэрээгээр тохирсон хэмжээгээр хариуцлага хүлээх тул энэ талаар гэрээнд хэрхэн зохицуулсныг үндэслэвэл зохих юм.



ХАМТРАН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТАЛААР

Иргэний хуулийн 242 дугаар зүйлийн 242.1, 242.3-т “үүрэг гүйцэтгэгчдийн хэн хэн нь үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээлгэн өгөх, үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн үүрэг гүйцэтгэгч тус бүрээс шаардах эрх бүхий байвал хамтран үүрэг гүйцэтгэгчид гэнэ”, “үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үзэмжээр аль ч үүрэг гүйцэтгэгчээс үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн шаардаж болох бөгөөд үүргийг бүхэлд нь гүйцэтгэх хүртэл үүрэг гүйцэтгэгчдийн хүлээсэн үүрэг хүчин төгөлдөр хэвээр байна” гэж тус тус заажээ.

Үүрэг гүйцэтгүүлэгч нь хамтран үүрэг гүйцэтгэгчийн аль нэгнээс үүргийг бүхэлд нь шаардах боломжгүй тохиолдол байна. Жишээ нь, Улсын ДЭЭД шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 26-ны 001/ХТ2017/00097 дугаар тогтоолоор магадлалыг хүчингүй болгож, шийдвэрт өөрчлөлт оруулахдаа “...нэхэмжлэгч нь Иргэний хуулийн 242 дугаар зүйлийн 242.3-т зааснаар өөрийн үзэмжээр аль ч үүрэг гүйцэтгэгчээс үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн шаардаж болох боловч хэрэгт авагдсан баримтаас үзвэл үүргийг зөвхөн нэг үүрэг гүйцэтгэгчээс шаардсаныг бүрэн хангах боломжгүй...” гээд үүрэг гүйцэтгэгч тус бүрийн хүлээх үүргийг тодорхойлж, төлбөрийн зарим хэсгийг гаргуулжээ. Өөр нэг жишээг дурдвал, Улсын дээд шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 01084 тогтоолд “...нэхэмжлэгч зээлийн төлбөрийг хариуцагч тус бүрээс шаардаагүйгээс гадна тэдгээрийн тус бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох боломжгүй байгааг шүүх анхаараагүй байна...” гээд үүргийг бүхэлд нь хамтран үүрэг гүйцэтгэгч нараас гаргуулсныг үндэслэлтэй гэж үзсэн байна.

Иргэний хуулийн 242 дугаар зүйлийн 242.11-т зааснаар хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй, эсхүл үүрэг гүйцэтгэгч тус бүрийн хүлээх үүргийг тодорхойлох боломжгүй бол тэдгээрийн үүрэг тэнцүү байна. Судалгаанаас үзэхэд зээлийн үүргийг хувааж хамтран үүрэг гүйцэтгэгч тус бүрээс шаардсаны дагуу үүргийг тэнцүү хувааж гаргуулсан жишээ мөн нилээд байна. Дээрхээс үзвэл, үүрэг гүйцэтгэгчдийн хамтран хүлээх үүргийг тодорхойлохдоо хэнд, ямар шаардлагыг холбогдуулан гаргасан, хамтран хүлээх үүргийг гэрээгээр буюу хуулиар, эсхүл үүргийн мөн чанартай /хуваагдах, үл хуваагдах шинж/ холбоотой хэрхэн тодорхойлж буйг тодруулах шаардлагатай.

Иргэний хуулийн 242 дугаар зүйлийн 242.5, 242.12-т зааснаар хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэн нэг нь үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид бүхэлд нь хүлээлгэн өгсөн бол бусад үүрэг гүйцэтгэгчид үүргээс чөлөөлөгдөж, хамтран хүлээх үүргийг гүйцэтгэсэн үүрэг гүйцэтгэгч нь хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол бусад үүрэг гүйцэтгэгчээс үүргийн гүйцэтгэлийг тус бүрд нь ногдох хэсгээр шаардах эрхтэй болно.

ФИНТЕК БА РЕГТЕК

ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ – KNOW YOUR CUSTOMER (KYC)

Санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахдаа харилцаж буй иргэн, байгууллагатай холбоотойгоор үүсэж болох эрсдэл, тэдгээртэй холбоотой мэдлэг, мэдээлэлтэй байхыг харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа гэх ба энэхүү нэр томъёо нь ихэвчлэн банк, санхүүгийн байгууллагуудын болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай дүрэм, журам, хуульд ашиглагддаг. Монгол Улсын хувьд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны талаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон санхүүгийн салбарын холбогдох зохицуулагч байгууллагууд дүрэм, журмууддаа тусгаж өгсөн байна.

Харилцагчаа таньж мэдэх өөрөөр хэлбэл тэдгээрийг хэн болохыг нь баталгаажуулж, бодит хүн, хориг арга хэмжээний жагсаалтад (НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан) багтаагүй зэргийг нь судалснаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас сэргийлэх боломжийг нэмэгдүүлдэг.

“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэ дугаараар “Fintech Futures”, “Compliance week”, “The Fintech Times” зэрэг финтекийн салбарын мэдээ, мэдээллийн томоохон цахим хуудаснуудаас харилцагчаа таньж мэдэх үйл ажиллагаатай холбоотойгоор санал болгож буй “The ABCs of eKYC” зөвлөмжөөс хүргэж байна.

Дараах шаардлагуудын улмаас харилцагчийг таньж мэдэх шаардлагатай болдог.

1. Луйврын эрсдэл

Онлайн орчин дахь хувь хүний мэдээллийн элбэг байдал нь залилан, луйвар үүсэх нэг бүрэлдэхүүн болсон. Цахимаар хувь хүний мэдээлэл (и-мэйл, нууц үг, кредит картан дугаар, эрүүл мэндийн бүртгэл гэх мэт)-ийг нэг хүнийхийг 25 центээс эхлээд 60 доллараар худалдаалдагийг холбогдох байгууллагууд олж илрүүлсэн байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар л гэхэд олон нийтэд хаалттай мэдээлэл алдагдсантай холбоотой 4000 гаруй гэмт хэрэг гарч 4.1 тэрбум “хувийн мэдээлэл” ил болсон байна.

Луйврын эрсдэлийг бууруулах болон брэндийн нэр хүндийг хадгалах зорилгоор байгууллагууд харилцагчдын цахим мэдээллийг шалгах, хянахтай холбоотой төсвөө нэмэгдүүлж байна.

2. Итгэлцэл

Харилцагчид болон онлайн хэрэглэгчид өөрсдийнх нь мэдээллийг хамгаална гэж “итгэснээр” бизнесийн байгууллагуудаар үйлчлүүлдэг. Сүүлийн үед хэрэглэгчид түр орон сууц, машин хамт түрээслэх, болзох болон бусад арга хэмжээнд оролцох зэргээр өөр хоорондоо харилцаж үйлчлэлд орж байгаа нь аль аль талынх нь хувьд бусад хэрэглэгчийн найдвартай байдлыг хангасан гэсэн “итгэл”-д суурилсан байдаг. Jimio (судалгааны байгууллага)-ын олон улсын итгэлцэл болон аюулгүй байдлын судалгаагаар АНУ болон Англи улсын онлайн хэрэглэгчдийн 64.4 хувь нь үйлчилгээ үзүүлэгч шинэ харилцагчдын талаарх мэдээллийг баталгаажуулах нь чухал гэж үзсэн байна.

3. Комплайнс

Харилцагчийг таньж мэдэх учир дутагдалтай байдал, түүний дагуулах томоохон эрсдэлүүдтэй холбоотойгоор хэд хэдэн заавар, зөвлөмж гэх мэт баримт бичгийг олон улсын байгууллагууд гэлтгүй улс орнууд өөрсдөө гаргасан байдаг. Эдгээр баримт бичгүүдийн шаардлагыг

хангах нь цаашдын үйл ажиллагаанд салшгүй чухал байдаг. Fenergo олон улсын МУТСТ-тэй холбоотой комплайнсын байгууллагаас гаргасан судалгаагаар сүүлийн 10 жилийн хугацаанд дэлхий даяар байгууллагууд нийтдээ ойролцоогоор 26 тэрбум ам.долларын торгуулийг мөнгө угаахтай тэмцэх болон харилцагчаа таньж мэдэх үйл ажиллагаатай холбоотой зөрчлийн улмаас төлсөн байна. Жишээлбэл 2018 онд Германы томоохон арилжааны банк болох ING санхүүгийн гэмт хэргээс сэргийлэх бодлогоо хэрэгжүүлэх чадамжгүй байсан нь хяналт, шалгалтын явцад ил болж, улмаар 900 сая ам.долларын торгуулийг төлжээ. 2010–2016 оны хооронд тус банкны Герман дахь салбар сэжигтэй гүйлгээг мэдээлэхгүй байснаар харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлээгүй гэж дүгнэгдсэн байна.

Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой тулгарч буй асуудлууд

Зардал: Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны зардал нь харьцангуй өндөр байдаг бөгөөд 2016 онд л гэхэд банкууд нийт 100 тэрбум ам.долларын зардлыг гаргасан байна. 2021 онд тус зардлыг 4–10 хувь хүртэл өснө гэж үзэж байна. Thomson Reuters-ийн судалгаагаар санхүүгийн байгууллага дунджаар 60 сая ам.долларын зардлыг харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд зарцуулдаг гэсэн үр дүнд хүрчээ.

Хэрэглэгчийн сэтгэл ханамж: Мөн Thomson Reuters-ийн 2017 оны судалгаагаар санхүүгийн байгууллагууд харилцагчийг шинээр бүртгэхдээ нэг харилцагчтай дунджаар 26 өдрийн хугацаанд 4 удаа холбогддог байна. Тус үзүүлэлтийн хувьд 2016 онд 24 өдөр байсан ба жил ирэх тусам өсөх хандлагатай байна.

Ингэж удаан хүлээлгэх нь банкуудын хувьд зардал ихтэй, хүлээх нь хэрэглэгчдийн хувьд төвөгтэй асуудал болж байна. Цахим үйлчилгээний байгууллага болох Signicat-ийн судалгаагаар Европын улс орнуудын банкны харилцагчдын талаас илүү хувь нь санхүүгийн шинэ үйлчилгээ авахаар бүртгүүлэх явцдаа дундаас нь хаясан гэх статистикийг харуулсан байна. Гол шалтгаан нь шинээр бүртгүүлэх нь цаг авсан, төвөгтэй үйл ажиллагаатай гэж харилцагчид үзсэн байна.

Нарийн, төвөгтэй байдал: Дээр дурдсан Thomson Reuters-ийн судалгаагаар санхүүгийн байгууллагууд дунджаар 307 ажилтныг харилцагчийг таньж мэдэх чиглэлээр (2016 онд 68 байсан) ажиллуулж байгаагаас гадна тэдгээрийн 34 хувь нь нөөцийн дутмаг байдал бол тус үйл ажиллагааг явуулах нэг том бэрхшээл гэж үзсэн байна.

Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд тогтсон стандарт гэж байхгүй учир байгууллага бүр хоорондоо харилцан адилгүйгээр хэрэгжүүлдэг. Зарим нь иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхийг шаардаж байхад зарим нь гадаад паспорт, төрсний гэрчилгээ зэргийг шаардлагатай гэж үздэг байна.

Технологи: Олон улсын байгууллагууд ерөнхийдөө зөвхөн харилцагчийн мэдэх (нууц үг, нууц асуулт гэх мэт) эсвэл эзэмших (тэмдэг /ID badge/) зүйлээс илүү биометрик буюу хурууны хээ, нүүрний хэлбэр, нүдний солонгон бүрхэвч зэргээр таних төхөөрөмжүүдийг ашиглахыг санал болгож байна. Үүнтэй холбоотойгоор цахим аюулгүй байдал, мэдээллийн технологийн дэд бүтэц зэрэг зардлуудыг өсгөж байгаа юм.

Хэрэглэгчээ таньж мэдэх 3 үе шат

1. Харилцагчийн мэдээллийг баталгаажуулах;
2. Зохих шалгалтыг хийх;
3. Тогтмол хяналтыг явуулах.

Энэ үе шатуудаас санхүүгийн байгууллагуудад хамгийн хүндрэлтэй байдаг зохих шалгалтыг хийх буюу “customer due diligence” шатын талаар товч дурдъя.

Түвшин	Тайлбар	Онцлог
Хялбарчилсан шалгалт Simplified due diligence	Үзүүлж буй үйлчилгээ эсвэл харилцагчид нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох боломж, магадлал багатай үед хэрэгжүүлэх хамгийн бага түвшний шалгалт	<input type="checkbox"/> Харилцагчийн мэдээллийг баталгаажуулах шаардлагагүй; <input type="checkbox"/> Бага дүнтэй дансны хяналтад тохиромжтой; <input type="checkbox"/> Цаашид тавигдах шаардлагыг нэмэх тохиолдол бий болох үүднээс тогтмол хянах шаардлагатай.
Стандарт шалгалт Standard due diligence	Эрсдэл тодорхой хэмжээнд байх бөгөөд тухайн эрсдэлийг үнэлэх боломжгүй үед хэрэгжүүлэх дунд түвшний шалгалт	<input type="checkbox"/> Ихэнх тохиолдолд ашиглагддаг; <input type="checkbox"/> Харилцагчийн мэдээллийг баталгаажуулах шаардлагатай; <input type="checkbox"/> Харилцагчтай бизнесийн харилцаа явуулахад шаардлагатай наад захын мэдээллийг цуглуулах; <input type="checkbox"/> Хяналт, шалгалттай холбоотой баримтыг хадгалах; <input type="checkbox"/> Цаашид тавигдах шаардлагыг нэмэх тохиолдол бий болох үүднээс тогтмол хянах шаардлагатай.
Сайжруулсан шалгалт Enhanced due diligence	Эрсдэл өндөр түвшинд байх бөгөөд тухайн эрсдэлийг үнэлэх боломжгүй үед хэрэгжүүлэх дунд түвшний шалгалт	<input type="checkbox"/> Улс төрд нөлөө бүхий эсэхийг шалгах; <input type="checkbox"/> Харилцагчийн хаяг, мэргэжил, гүйлгээний төрөл, хэмжээ зэрэг эрсдэлийн хүчин зүйлс олонтой; <input type="checkbox"/> Харилцагчийн мэдээлэл эсвэл орлогын эх үүсвэрийг батлах нэмэлт мэдээллийг шаарддаг; <input type="checkbox"/> Засгийн газраас тавьсан хориг, жагсаалт зэргийг ашиглан шалгадаг; <input type="checkbox"/> Бусад мэдээ, мэдээллийн эх үүсвэрийг ашигладаг; <input type="checkbox"/> Хяналт, шалгалттай холбоотой баримтыг хадгалах; <input type="checkbox"/> Цаашид тавигдах шаардлагыг нэмэх тохиолдол бий болох үүднээс тогтмол хянах шаардлагатай.

Эх сурвалж: “The ABCs of eKYC”

Үйлчилгээ үзүүлэгчид болон харилцагчдад аль алинд нь тулгарч байгаа асуудлуудыг багасгах үүднээс харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хялбаршуулан электрон хэлбэрт шилжүүлэх шийдлийг технологийн компаниуд гаргаж ирсээр байгаа бөгөөд eKYC нь дараах хэд хэдэн давуу талтай:

- Цаасгүй систем;
- Түргэн шуурхай;
- Үйл ажиллагааны болон гүйлгээний ил тод байдал;
- Зохицуулагч байгууллагад хянахад хялбар гэх мэт.

Дараах зураглалд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг электрон хэлбэрээр (eKYC) явуулж болох боломжийг үзүүлээ



“The ABCs of eKYC” зөвлөмжийг дараах вэбсайтаас татаж авах боломжтой.



СУДЛААЧИЙН ИНДЭР

ЭХ ОРНЫ ХИШИГ ИРГЭДИЙН 1072 ШИРХЭГ ХУВЬЦААГ ЗОХИСТОЙ УДИРДАХ ЗАМААР ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

Г.БАТ-ЭРДЭНЭ, УДИРДАГЧ БАГШ: С.ЦОЛМОН

Энэхүү бүтээл нь СЗХ-ноос 2019 оны 11 дүгээр сард зохиогдсон “Эрдэм шинжилгээний хурал”-ын оюутны ангилалд дэд байр эзэлсэн бүтээл бөгөөд СЗХ-ны байр суурийг илэрхийлээгүй болно.

ХУРААНГУЙ

Уг судалгааны ажлаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК нээлттэй компани болохтой холбогдуулан иргэдийн 1072 ширхэг хувьцааны эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн хөгжилд үзүүлэх нөлөө болон үр өгөөжтэй удирдах арга, зөвлөмжийг боловсруулахыг зорилгоо. Шинжилгээг хийхдээ үндсэн гурван бүлэгт хуваан үзсэн бөгөөд эхний хэсэгт хувьцааг зохицуулалтгүй гаргаснаас үүдэх эрсдэл, эдийн засгийн үзүүлэлт тэр дундаа инфляцид үзүүлэх шокын нөлөөг Вектор авторегресс загвар (VAR)-ыг ашиглан судалсан. Тодорхойлох хувьсагчдыг улирлын нөлөөтэй эсэхийг шалгасан ба өгөгдсөн түвшиндээ тогтвортой эсэхийг Unit root test-ийн шалгуураар шалгаж шинжилгээний арга сонгосон. Харин хоёрдугаар бүлэгт баялгийн тэгш, шударга хуваарилалтыг бий болгох, эдийн засгийн үр өгөөжтэй удирдах зорилгын хүрээнд хөрөнгө оруулалтын сан байгуулах санал гарган судалсан бөгөөд иргэд хувьцаагаа хөрөнгө оруулалтын санд шилжүүлснээр бий болох боломжит өгөөжийн түвшинг Марковичийн дундаж хэлбэлзлийн арга болон Монте-Карло симуляцийн багц сонголт оновчлолын аргаар үнэлсэн. Эцсийн бүлэгт хөрөнгө оруулалтын сан байгуулснаар хөрөнгийн зах зээлийн хөгжилд үзүүлэх нөлөө, цаашдын эерэг төсөөллийг судлав. Судалгааг товч дүгнэвэл иргэдийн 1072 ширхэг хувьцааг зохицуулалтгүй хөрөнгийн зах зээл дээр гарган иргэд хувьцаагаа худалдах тохиолдолд эдийн засагт сөрөг шокын нөлөөтэй ба инфляцийг суурь утгаас 3 улирлын дараагаар 2 хувиар өсгөхөөр байна. Уг хувьцааг хөрөнгө оруулалтын сан хэлбэрт шилжүүлэн Топ 20 индексийн 17 хувьцаагаар багц бүрдүүлэн арилжаалбал жилийн хамгийн бага болон их хүлээгдэж буй өгөөж нь харгалзан 1.26, 25 хувь байгаа бол хамгийн бага болон их эрсдэлийн түвшин 11 болон 35 хувьтай байна. Мөн хөрөнгө оруулалтын сангийн мөнгөн урсгалын өсөлт нь ДНБ-ий өсөлт болон хөрөнгийн захын өгөөж, зах зээлийн үнэлгээг өсгөх шалтгаан болдог бөгөөд 2 улирлын дараагаар хамгийн хүчтэй нөлөөлдөг байна.

Түлхүүр үг: 1072 ш хувьцаа, Хөрөнгө оруулалтын сан, Вектор авторегресс загвар, Марковичийн дундаж хэлбэлзлийн арга, Монте-Карло симуляци

ОРШИЛ

Манай улсад 1990-ээд онд зах зээлийн эдийн засагт шилжиж өмч хувьчлал явагдах болсонтой холбоотой хөрөнгө оруулалтын эрхийн бичиг буюу цэнхэр, ягаан тасалбарыг тухайн үеийн хоёр сая гаруй иргэнд тараасан билээ. Харамсалтай нь дийлэнх иргэд маань уг цэнхэр, ягаан тасалбарын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байсан нь эрхийн бичгээ ашиглахгүй хадгалах, бусдад хямд үнээр борлуулах шалтгаан болжээ. Үүнээс үүдэн мэдээлэлд ойрхон байсан хэсэг бүлэг цөөн хэдхэн хүмүүсийн гарт нийгмийн баялгийн ихэнх хэсэгт төвлөрч, орлогын ялгаатай байдал улам бүр даамжирсаар байна. Үүнтэй нэгэн адил 2008 оны 35-р тогтоолд МАХН уул уурхайн баялгийн орлогоос иргэн бүрт тэгш хүртээх зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн

1072 ширхэг хувьцааг эзэмшүүлэхээр заасан байдаг. Энэхүү 1072 ширхэг хувьцааг одоогийн байдлаар 2511,000 иргэн эзэмшиж буй бөгөөд өмнөх цэнхэр ягаан тасалбарын алдааг дахин давтахгүйн тулд нарийн тооцоо судалгаанд үндэслэн удирдах шаардлагатай байна. Бидний тооцоолсноор иргэдийн 1072 ширхэг хувьцааг төрөөс хараат бус мэргэжлийн багаар удирдуулах замаар хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын санд хуримтлуулах нь зүйтэй хэмээн үзэж байгаа бөгөөд ингэснээр хөрөнгийн зах зээлийн хөгжилд нэн шаардлагатай байгууллагын хөрөнгө оруулагч бий болж макро түвшинд баялгийн тэгш шударга хуваарилалт, эдийн засгийн өсөлтийг дэмжих давуу талуудтай бол хувь хүнд эрсдэлийг тараан байршуулах, хөрөнгөө мэргэжлийн чадварлаг багаар удирдуулан өсгөх гэх мэт боломжийг нээх юм.

Вектор авторегресс загварын товч танилцуулга: Вектор авторегресс (VAR) загвар нь эдийн засгийн хувьсагчид хоорондын цаг хугацаа дамжсан хамаарлыг илэрхийлдэг динамик загвар юм. VAR загварын талаар ойлголттой болохын тулд дараах 2 хувьсагч бүхий VAR загварыг авч үзье. t хугацаанд авч үзэж буй хувьсагч X_t болон Y_t нь дор харуулсан хамаарлаар илэрхийлэгддэг байг.


$$X_t = a_0 + a_1X_{t-1} + a_2Y_{t-1} + uX_t$$

$$Y_t = b_0 + b_1X_{t-1} + b_2Y_{t-1} + uY_t$$


Тэгшитгэлд харуулсан алдааны илэрхийлэл uX_t , uY_t нь хоёул тэг математик дундажтай, тогтмол дисперстэй байна. t хугацаанд авч үзэж буй X_t болон Y_t нь харгалзан өмнөх хугацааны X_{t-1} , Y_{t-1} гэсэн хувьсагчдаар тайлбарлагдаж байгаа авторегресс загвар юм. Загварт буй a болон b нь бидний үнэлэхийг зорьж буй параметрийн утга юм. VAR загвар нь тухайн хугацааны болон түүний өмнөх хугацааны хувьсагчдын хамаарлыг илэрхийлсэн загвар тул динамикийн загвар ч гэж нэрлэдэг.

Зураг 1: Хариу үйлдлийн нөлөө


Response to Cholesky One S.D. (d.f. adjusted) Innovations \pm 2 S.E.
Response of INF_SA to INF_SA




Response of INF_SA to REVGROWTH_SA



Response of REVGROWTH_SA to INF_SA



Response of REVGROWTH_SA to REVGROWTH_SA



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хариу үйлдлийн үр дүнг харвал орлогын өсөлт нь инфляцийн түвшинд гурван улирлын дараа хүчтэй нөлөөлдөг бөгөөд орлогын 10 хувийн өсөлт нь инфляцыг суурь утгаас 0.02 нэгж хувиар өндөр гарахаар байна. Өөрөөр хэлбэл, орлого 1,000,000 төгрөгөөр өсөхөд инфляцийн түвшин суурь утгаас 2 нэгж хувиар өндөр гарахаар байна.

Монте Карло симуляцийн аргын тавил: Монте–Карло аргачлалаар түүвэр зохиож багцын эрсдэлийн тооцоолж буй хугацааны үеийн тархалтыг олох замаар эрсдэлийг тооцоолдог. Тус аргачлал нь геометр Броуны хөдөлгөөний стохастик дифференциал тэгшитгэл дээр тулгуурладаг бөгөөд стохастик процесс нь дараах байдалтай байна.

$$\frac{dY}{Y} = \mu dt + \sigma dW \quad (1.15)$$

Энд, W –стандарт Wiener процесс.

Стандарт Wiener процессыг стандарт нормаль тархалттай санамсаргүй хэмжигдэхүүнээр илэрхийлдэг. Дээрх тэгшитгэлээс Монте–Карло

аргачлалаар VaR тооцоолох ерөнхий тэгшитгэлийг бичвэл:

$$\Delta Y_t = Y_{t-1}(\mu_{t-1}\Delta t + \sigma_{t-1}z_t\sqrt{\Delta t}) \quad (1.16)$$

Энд, z_t – стандарт хэвийн тархалттай санамсаргүй хэмжигдэхүүн

Хүснэгт 1: Монте–Карло симуляцийн аргаар хүлээгдэж буй өгөөжийг таамаглах

Итгэлцлийн түвшин	Итгэлцлийн түвшин дэх өгөөжийн утга
75%	30%
95%	1%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Монте–Карло симуляцийн арга нь детерминастик загварт санамсаргүй хувьсагчдыг олон удаа үүсгэн оруулж загварыг үнэлдэг. Хувьцааны сангийн эхлэлийн хөрөнгө 2 их наяд 800 тэрбум төгрөг гэж үзвэл 17 хувьцааны багцын хамгийн бага эрсдэлтэй оновчлолд 95 хувийн итгэлцлийн түвшинд үнэлгээ нэг жилийн дараагаар 2 их наяд 700 тэрбум төгрөгөөс буухгүй. Харин багцын хамгийн өндөр өгөөжийн оновчлолд 75 хувийн итгэлцлийн түвшинд сангийн үнэлгээ хамгийн багадаа 3 их наяд төгрөг байна.

Хүснэгт 3. Учир шалтгааны тестийн үр дүн (Granger Causality test)

	Dependent Variables		
	(1)	(2)	(3)
Sample: 49 observations	Flows (t)	Flows (t)	Flows (t)
Constant	-0.007 (-1.026)	-0.007 (-1.331)	-0.003 (-0.746)
Flows (t-1)	0.462*** (3.494)		0.402*** (4.342)
Returns (t)		0.300*** (5.851)	0.289*** (6.539)
R ²	20.7%	45.2%	61.7%
Adjusted R ²	19.0%	44.1%	60.0%
p-value	0.001	0.000	0.000

White heteroskedasticity-consistent t-statistics are in parentheses. *** Significance at the 1% level.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Зах зээлийн үнэлгээ нь ДНБ-ий учир шалтгаан болохгүй байсан ба эсрэгээрээ ДНБ нь зах зээлийн үнэлгээний учир шалтгаан болж байв. Иймд дээр дурдсан хамаарлуудаас эдийн засгийн өсөлт үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжигч учир шалтгаан нь болдог гэсэн таамаглал батлагдаж байна. Эдийн засгийн өсөлтөөс зах зээлийн үнэлгээний дүн хамаарч байгаа нь өөрөө мөчлөг дагасан шинжтэй буюу эдийн засгийн өсөлттэй жилүүдэд хэт халах буюу үнэт цаасны үнэ, ханш дагаж огцом нэмэгддэг бол эдийн засгийн уналттай жилүүдэд зах зээл дээрх хувьцааны үнэ ханш эрс буурч байв.

Хүснэгт 2: Хөрөнгө оруулалтын сангийн мөнгөн урсгал Хөрөнгийн зах зээлийн өгөөжийн түвшний хамаарал Португали улс

VEC Granger Causality/Block Exogeneity Wald Tests

Date: 07/19/19 Time: 11:03

Sample: 2004Q1 2019Q1

Included observations: 58

Dependent variable: D(GDP)

Excluded	Chi-sq	df	Prob.
D(MARKET)	6.998110	2	0.0302
All	6.998110	2	0.0302

Dependent variable: D(MARKET)

Excluded	Chi-sq	df	Prob.
D(GDP)	2.077421	2	0.3539
All	2.077421	2	0.3539

Эх сурвалж: *The relation between mutual fund flows, stock returns and macroeconomic variables: evidence from Portugal.*

Дээрх загварын үнэлгээний утгаас харахад хөрөнгийн зах зээлийн өгөөж болон хөрөнгө оруулалтын сангийн урсгал нь эерэг хамааралтай бөгөөд 2 улирлын дараагаар дээд цэгтээ хүрч эндоген хувьсагчийг 60 хувийн түвшинд тайлбарлаж байна. Мөн хөрөнгө оруулалтын сангийн мөнгөн урсгал 1 хувиар өөрчлөгдөхөд хөрөнгийн зах зээлийн өгөөж 0.300 хувиар өөрчлөгдөх ба Р ажиглалтын утга 0.001 буюу 5 хувийн статистик ач холбогдолтой байгааг илэрхийлж байна.

ДҮГНЭЛТ

Судалгааг дүгнэвэл иргэдийн хөрөнгийн захын талаарх мэдлэг дутмаг энэ үед 1072 ширхэг хувьцааг нээлттэй арилжаалах нь тодорхой эрсдэлийг дагуулна. Тухайлбал иргэд хувьцаагаа нийгмийн халамж хэмээн ойлгон худалдах тохиолдолд эдийн засгийн зарим үзүүлэлтүүдэд сөрөг шокын нөлөөг бий болгох бодит эрсдэл үүсээд байна.

Орлогын 10 хувийн өсөлт нь инфляцийг 3 улирлын дарааг суурь утгаас 0.04 нэгж хувиар өндөр гаргахаар байна. Өөрөөр хэлбэл орлого 1,000,000 төгрөгөөр өсөхөд инфляцын түвшин суурь утгаас 4 нэгж хувиар өснө гэсэн үг.

Харин 1072 ширхэг хувьцааг хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан хэлбэрт хуримтлуулан 1–р ангиллын 17 хувьцааны багцын хувьд жилийн хамгийн бага болон их хүлээгдэж буй өгөөж нь харгалзан 1.26, 25 хувь байгаа бол хамгийн бага болон их эрсдэлийн түвшин 11, 35 хувьтай байна. Мөн хувьцааны сангийн эхлэлийн хөрөнгө 2 их наяд 800 тэрбум төгрөг гэж үзвэл 17 хувьцааны багцын хамгийн бага эрсдэлтэй оновчлолд 95 хувийн итгэлцлийн түвшинд үнэлгээ нэг жилийн дараагаар 2 их наяд 700 тэрбум төгрөгөөс буухгүй. Харин багцын хамгийн өндөр өгөөжийн оновчлолд 75 хувийн итгэлцлийн түвшинд сангийн үнэлгээ хамгийн багадаа 3 их наяд төгрөг байна.

1072 ширхэг хувьцааг нээлттэй хамтын санд байршуулах гэж буй учир хамтын сангийн эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан боловсруулан дотоод менежментийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг

олон улсын туршлага дээр үндэслэн судлах хэрэгтэй.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд хамтын сангийн нэгж эрхийг заавал бэлэн мөнгө хэлбэрээр гаргана гэсэн байдаг. Уг 1072 ширхэг хувьцааг иргэд худалдаад дахин хамтын санд байршуулна гэдэг цаг хугацаа алдахаас гадна дахин төвлөрөх магадлал маш бага хэмээн үзэж байна. Тиймээс засгийн газрын зүгээс энэ тал дээр тодорхой зохицуулалт хийх шаардлагатай.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

- Иргэдийн 1072 ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээл дээр зохицуулалттай гаргах;
Өөрөөр хэлбэл, 1072 ширхэг хувьцааны арилжаалах эрхийг 268 ширхэгээр 4 хэсэг болгон хуваах юм. Ингэснээр иргэдэд эхний 268 ширхэг хувьцааг арилжаалах эрхийг өгснөөр хөрөнгийн зах зээл дээр тоглолт хийх талаар тодорхой ойлголттой болох юм.
- Иргэдийн 1072 ширхэг хувьцааг нээлттэй хөрөнгө оруулалтын сан хэлбэрт шилжүүлэн мэргэжлийн багаар удирдуулан арилжаалах;
Иргэд эхний 268 ширхэг хувьцааг арилжаалснаас тодорхой хугацааны дараа дахин судалгаа хийснээр иргэдэд хөрөнгө оруулалтын сан хэлбэрт шилжүүлэх санал тавих бөгөөд үлдсэн 804 ширхэг хувьцааг хөрөнгө оруулалтын сан хэлбэрт шилжүүлэх юм;
- Мэргэжлийн холбоо байгуулан хөрөнгө удирдах менежментийн компанийг сонгон шалгаруулах;
Мэргэжлийн холбоо нь тухайн салбарын мэргэжилтнүүдийн үр чадвар, ёс зүйтэй байдалд үнэлгээ өгч, хөрөнгө удирдах тусгай зөвшөөрлийг олгоно.

АШИГЛАСАН НОМ

- Д.Ган-Очир, Монголын инфляцын бүтцийн загвар (smim): Эх орны хишиг/ эрдэнийн хувийн эдийн засагт үзүүлэх нөлөө
- Мөнгөний бодлогын хэлтсийн эдийн засагч Д.Ган-Очир, цалин болон орлого, инфляци хоорондын уялдаа
- Э.Ууганцэцэг, Бизнесийн ахисан түвшний сургууль шинжлэх ухаан технологийн их сургууль, Д.Энхтуяа./доктор.ph.d/ БУХС-ын бизнесийн удирдлагын салбар, профессор “Хөрөнгө оруулалтын сангийн стратегийн сонголт”
- Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны зохицуулалтын газар, ахлах хянан шалгагч Э.Эрдэнэцэцэг, Хөрөнгө оруулалтын сан, кастодианы үйл ажиллагаа, хадгаламжийн бичиг /dr/ тэдгээрийн эрх зүйн зохицуулалт
- Долгормаа б., Үнэт цаасны зах зээл дэх хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны чиг хандлага (2013), бизнесийн удирдлагын бакалаврын зэрэг горилсон судалгааны ажил, СЭЗДС
- Монголын хөрөнгийн бирж, Монгол дахь хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, цаашид шинээр сан байгуулах боломж (2006)
- Robert alan hill, Portfolio theory and investment analysis, 2010
- Үндэсний статистикийн хороо
- Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны зах зээлийн 2018 оны хагас жилийн тойм
- Санхүүгийн зохицуулах хороо “Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөв”

ТАНИЛЦУУЛГА



МОНГОЛЫН ДААТГАЛЫН ХОЛБОО
INSURANCE ASSOCIATION OF MONGOLIA



МОНГОЛЫН ДААТГАЛЫН
ИНСТИТУТ

МОНГОЛЫН ДААТГАЛЫН ХОЛБОО

“Монголын Даатгалын Холбоо” ТББ нь анх “Монголын Даатгагчдын Холбоо” нэрээр 2004 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын шийдвэрээр байгуулагдсан, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, тэдгээрийн эрх ашгийн төлөө гишүүддээ үйлчилдэг, бие даасан, ашгийн бус мэргэжлийн холбоо юм.

Эрхэм зорилго: Холбооны зорилго нь Монгол Улсын даатгалын салбарын тогтвортой хөгжлийг хангахад даатгалын компаниудын оролцоог нэгтгэх, энэхүү холбоогоор дамжуулан даатгагчдын болон олон нийтийн эрх ашгийг хамгаалах, Монголын даатгалын зах зээлийн өсөлт, хөгжлийг олон улсын хэмжээнд хүргэх, мэргэжлийн сургалт, судалгааны туслалцааг үзүүлэх юм.

Холбоо гурван үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Нэгдүгээрт, даатгалын салбарын хөгжлийн бодлого, хамтын ажиллагааны уялдаа холбоог зохицуулах. Хоёрдугаарт, даатгалын салбарыг төлөөлж, бусад салбарын хөгжил, төрийн бодлого, хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхойлоход хувь нэмэр оруулах. Гуравдугаарт, олон нийт рүү хандсан даатгалын зөв мэдлэг, боловсрол олгох, мэргэжлийн богино хугацааны болон урт хугацааны сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Гадаад харилцаа: Сургалт, хамтын ажиллагааны чиглэлээр Япон улсын Ердийн даатгалын холбоо, Даатгалын сургууль, Амьдралын даатгалын сургалтын ФАЛИА байгууллага, Солонгос улсын Ердийн даатгалын холбоо, Энэтхэг улсын Даатгалын сургууль, Малайз улсын Даатгалын Институт зэрэг даатгалын мэргэжлийн холбоод, сургуулиудтай байнгын харилцаатай ажиллаж байна.



Хамтын ажиллагаа: Холбоо нь гишүүдээ төлөөлөх үйл ажиллагааны чиглэлийн дагуу холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, хяналт зохицуулалтын байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хороотой байнгын харилцаа холбоотой хамтран ажиллаж байна. Үүнд: Даатгалын багц дүрэм, журам, тогтоол шийдвэртэй холбоотойгоор гишүүн компаниудын санал хүсэлтийг нэгтгэх, өргөтгөсөн хэлэлцүүлэг зохион байгуулах, салбарын

зохицуулалтыг уян хатан болгох, даатгагчийн нөөц сангийн тооцоолол, төлбөрийн чадварын журмын зохицуулалтуудыг сайжруулах, салбарын бусад мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг өргөжүүлэх зэргээр даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах тэднийг зохицуулалтын бодлогоор дэмжих, даатгуулагчийн эрхийг хамгаалах чиглэлээр холбогдох саналуудыг зохицуулалтын байгууллагадаа хүргүүлж, хамтран ажилласан байна.

Мөн хамтын ажиллагааны гэрээгээр талууд салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих замаар салбарын үйлчилгээийг чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх, даатгалын салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зэрэг чиглэлүүдээр хамтран ажиллаж байна.



Гишүүнчлэлийн хувьд СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан нийт 16 даатгалын компани нь Холбооны жинхэнэ гишүүн ба үүнээс ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1 компани гишүүнээр элссэн байна.

Мөн “Хадгаламжийн даатгалын корпораци” ХК, даатгалын нэгдсэн шуурхай албаны “Авто СОС” ХХК зэрэг байгууллагууд холбооны дэмжигч гишүүнээр элсэн үйл ажиллагаагаа явуулж байна.

МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО



Монголын Банкны Холбоо (МБХ) нь Монголбанкнаас албан ёсоор зөвшөөрөл авч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа банкны болон бусад санхүүгийн байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, гишүүддээ үйлчилдэг, хараат бус, бие даасан, ашгийн бус төрийн бус байгууллага юм.

Анх 2000 онд үүсгэн байгуулагдаж байсан бол өдгөө арилжааны 13 банк, Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сан, Сумитомо мицуи банкны корпорацийн төлөөлөгчийн газар, Токио-Мицубиши банк Юу Эф Жэй банкны төлөөлөгчийн газар, Банк Оф Чайна банкны төлөөлөгчийн газар, Виза Интернейшнл олон улсын байгууллагын Ази-Номхон далай Солонгосын бүсийн төлөөлөгчийн газар, ЮнионПэй Интернейшнлийн төлөөлөгчийн газар, Зээлийн мэдээллийн төв ХХК, Банк санхүүгийн академи ТББ, Монголын Ипотекийн Корпораци ХХК, Бринкс Монгол ХХК зэрэг байгууллагуудыг эгнээндээ нэгтгэсэн санхүүгийн салбарын мэргэжлийн холбоо болон өргөжөөд байна.

МБХ нь нийт гишүүдийн хууль ёсны, нийтлэг ашиг сонирхол, эрхийг төлөөлөн хамгаалах, гишүүд болон зохицуулагч байгууллагуудын хоорондын гүүр болох, банк санхүүгийн салбарын өмнө тулгарсан бодлогын асуудал, түүний оновчтой шийдэл рүү нийт гишүүдийн үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх, цаашлаад санхүүгийн салбарын үр ашигтай, эрүүл хөгжилд манлайлж, гишүүдийн оролцоо, бодитой хувь нэмрийг татан оруулах зорилготой.



МБХ нь Санхүүгийн зохицуулах хороотой 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан бөгөөд гэрээний дагуу даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлж буй банкуудын ажилтнуудад даатгалын зуучлалын эрх олгох болон мэргэшүүлэх сургалтыг МБХ-ноос зохион байгуулах боломжтой болсон юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧДИЙН ХОЛБОО

Монголын Хөрөнгө, Хохирол Үнэлэгчдийн Холбоо нь 2013 онд үүсгэн байгуулагдсан ба даатгалын хохирол үнэлэгч компани, мэргэшсэн үнэлгээчдийг эгнээндээ нэгтгэсэн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

Зорилт:

- ✓ Монгол Улсад хохирлын үнэлгээний үйл ажиллагааг төлөвшүүлэн хөгжүүлэх, эрсдэлийн бодит судалгаа гаргах учир шалтгааныг тодруулах, эрсдлийг бууруулах;
- ✓ Даатгалын зах зээлийн тогтвортой хөгжлийг хангахад үнэлгээний компаниудын үүрэг, оролцоог дээшлүүлэх;
- ✓ Даатгагчдын болон даатгуулагчдын хоорондын итгэлцлэлийг бэхжүүлэх;

- ✓ Даатгалын хохирол үнэлэгч гишүүн байгууллагуудынхаа нэр хүнд, хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах,
- ✓ Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай харилцах, мэргэжлийн сургалт зохион байгуулахад оршино.

Энэхүү холбоо нь үйл ажиллагаа, сахилга хариуцлага, хууль журам үнэлгээний үйл явцыг боловсронгуй болгох зорилгоор хууль, журманд заасан мэргэжлийн хороо, ёс зүйн хороо, хяналтын хороодыг байгуулан ажиллаж байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

- ✓ Мөн БНСУ-ын Хохирол Үнэлэгчдийн Холбоотой 2014 оны 8 дугаар сарын 19-ний өдөр “Хамтран ажиллах санамж бичиг”-т гарын үсэг зурж баталгаажуулснаар засаглалын чадавхаар тэргүүлэгч орнуудын туршлага судлах, боловсон хүчин бэлтгэх, сургах, хууль тогтоомжийг сайжруулах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.
- ✓ БНСУ-ын Хохирол Үнэлэгчдийн холбоотой хамтран 2015 оны 5 дугаар сарын 18-23-ны өдрүүдэд “Ослын улмаас учирсан хохирлын үнэлгээ” сэдвээр сургалт зохион байгуулж хүний эрүүл мэнд, амь нас, сэтгэл санаа, нэр төрд учирсан хохирлыг үнэлэх сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулж ХЭҮК, СЗХ, ШШҮТ, Тээврийн прокурор, Даатгалын байгууллагууд, АТГ, ТЕГ, гишүүн байгууллагууд, эрдэмтэн багш нар зэрэг 70 гаруй мэргэжилтнүүдийг хамрууллаа.
- ✓ Агаарын тээвэр, авто тээвэр, төмөр замын тээвэрт ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд учирсан хохирлын үнэлгээ тогтоох талаар Тээврийн прокурорын газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо, МХХҮХ-ны хамтын ажиллагаа

МХХҮХ нь СЗХ-той байгуулсан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр даатгалын хохирлын эрх олгох сургалтын хөтөлбөрийг СЗХорооны Даатгалын газраар батлуулан, хамтран сургалт явуулж байна. Мөн даатгалын хохирлын эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хяналт тавих болон даатгалын хохирол үнэлгээний тайлантай холбогдох өргөдөл, гомдол шийвэрлэхэд Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд СЗХ-той мэдээлэл солилцох хүрээнд хамтран ажилладаг билээ.



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

ЗАРИМ ХОЛБООДЫН ГЭРЭЭГ СУНГАЛАА

Санхүүгийн зохицуулах хороо 2020 оны 5 дугаар сарын 05–ны өдөр аудитын болон хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд хийх сургалтыг “Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт”, “Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт”, хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн арилжааны зуучлагчийн арилжаанд оролцогч брокерийн сургалтыг “Хөдөө, аж ахуйн гаралтай бараа түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо”–д зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээг тус тус байгууллаа.



ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД ЗОРИУЛЖ ГАРЫН АВЛАГА БЭЛЭН БОЛГОЛОО

Санхүүгийн зохицуулах хорооноос олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Даатгалын ач холбогдол, мөнгө угаахтай тэмцэх, комплайнс, компанийн засаглал зэрэг сэдвээр гарын авлага гаргав.



ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД ЗОРИУЛЖ ЦУВРАЛ ШТОРК ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ТҮГЭЭЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хорооноос олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Хадгаламж, зээлийн хоршооны ашиг тус юу вэ, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар сэдвээр богино хэмжээний анимейшн бэлтгэж олон нийтэд үргэлжлүүлэн түгээж байна. Энэхүү мэдээллийг Хорооны цахим хуудас, твиттер, ютүб, Монголбанк, Насан туршийн боловсролын үндэсний төв болон Хорооны 21 аймаг, 9 дүүргийн орон нутгийн төлөөлөгчөөр дамжуулан хүргэж байна.

МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДТОЙ ХАМТРАН ЦАХИМ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дэлхийн улс орнуудад коронавирусийн (КОВИД-19)–ын дэгдэлт нэмэгдэж буйтай холбогдуулан Монгол Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа олон хариу арга хэмжээний нэг нь иргэд олноор цугларахгүй байх хязгаарлалт юм. Улсын онцгой комиссын шийдвэрийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран даатгалын зуучлагчийн болон аудиторуудад зориулсан сургалтыг цахимаар зохион байгууллаа.



ХЭРЭГЛЭГЧ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд

заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 137 өргөдөл, гомдол ирсэн байна.

Нийт өргөдлийн тоо (улирлаар)

№	Салбар	2017.1	2017.2	2017.3	2017.4	2018.1	2018.2	2018.3	2018.4	2019.1	2020.1
1	Даатгал	42	23	29	45	40	38	25	47	43	90
2	Үнэт цаас	23	12	12	20	28	29	21	30	17	26
3	ББСБ	13	9	7	13	20	11	11	14	20	20
4	ХЗХ	8	5	1	5	4	2	30	17	2	1
	Нийт	86	49	49	83	92	80	87	108	82	137

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээл, хадгаламж зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо буурсан бол даатгалын салбартай холбоотой өргөдлийн тоо өсөж, ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1–т тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Хороонд хандаж, 2020 оны 1 дүгээр улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор үзүүлэв.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Тайлант хугацаанд нийт 137 өргөдөл, гомдол ирснээс: Өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт дараах байдалтай байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Өргөдлийн тоо
Шийдвэрлэж, хариуг өгөв. Үүнээс:	
Хугацаанд нь шийдвэрлэсэн	121
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	–
Шийдвэрлэх шатандаа байгаа. Үүнээс:	
Хуулийн хугацаанд хянагдаж буй	10
Хугацааг нь сунган хянагдаж буй	6

Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор)





КОМПАНИЙН ТУЗ-ИЙН НЭГ ГИШҮҮНИЙГ СОНГОХОД ШААРДАГДАХ ХАМГИЙН БАГА САНАЛЫН ТООГ ТООЦОЖ БОЛОХ АРГАЧЛАЛ

Санал хураах кумулятив аргыг хэрэглэх тохиолдолд ТУЗ-ийн нэг гишүүнийг сонгоход шаардагдах хамгийн бага хувьцааны хувь хэмжээ

Компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн гишүүдийн нийт тоо	Хувьцааны хувь хэмжээ, %
9	10.0000+Д
10	9.0909+Д
11	8.3333+Д
12	7.6923+Д
13	7.1429+Д
14	6.6666+Д
15	6.2500+Д

Кумулятив аргыг хэрэглэх үед ТУЗ-ийн нэг гишүүнийг сонгоход шаардлагатай хамгийн бага саналын тоог тооцоход дараах томъёог ашиглаж болно:

$$C = [N/T + 1] + D$$

- С ТУЗ-ийн нэг гишүүнийг сонгоход шаардлагатай саналын тоо;
Т компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн гишүүдийн нийт тоо;
Н хувьцаа эзэмшигчдийн хуралд тухайн асуудлаар саналын эрхтэйгээр оролцож буй нийт саналын эрхийн тоо;
Д нэг нэр дэвшигчийн бусдын өмнө давуу талтай байх хамгийн бага саналын тоо. Энэ саналын тоо нь хамгийн ихдээ нэг, эсхүл бутархай тоогоор илэрхийлэгдэнэ.

Дээрх томъёогоор тооцсон ТУЗ-ийн нэг гишүүнийг сонгоход шаардлагатай хамгийн бага саналын тоо нь ТУЗ-ийн гишүүдийн нийт

тоо болон хувьцаа эзэмшигчдийн хуралд тухайн асуудлаар саналын эрхтэй оролцож буй нийт саналын тооноос шууд хамаарна.

ТУЗ-ийн нэг гишүүнийг сонгоход шаардлагатай хамгийн бага саналын тоог тооцох жишээ: Компанийн ТУЗ-ийн 11 гишүүн сонгогдож байгаа ба хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрх бүхий нийт 1,000 ширхэг хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцох тохиолдолд дээрх хүснэгтийг ашиглавал нэг гишүүнийг сонгоход хамгийн багадаа нийт саналын эрх бүхий хувьцааны 8.3333 хувьтай байх шаардлагатай. $1/11,000 * 8.3333 \% = 916.663$ санал буюу 83.33 ширхэг хувьцаа/

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч дангаараа /бусадтай нэгдмэл сонирхолгүйгээр/ саналаа ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид өгөх тохиолдолд саналын болон хувьцааны тоо бүхэл тоогоор илэрхийлэгдэж, 917 саналын эрх буюу 84 ширхэг хувьцаа болно.

Хувилбар Б: Хэд хэдэн хувьцаа эзэмшигчид нэгдэн саналаа нэгтгэх тохиолдол буюу хоёр хувьцаа эзэмшигч тус бүр 84 ширхэг хувьцаа эзэмшдэг ба гуравдагч хувьцаа эзэмшигч 83 ширхэг хувьцааг эзэмшдэг. Эдгээр 84, 83 ширхэг хувьцаа нь тус тус 924 болон 913 тооны саналтай болох ба нэг гишүүнийг сонгоход хамгийн багадаа 917 саналын эрх буюу 84 ширхэг хувьцаа шаардлагатай.

Энэ тохиолдолд эхний 2 хувьцаа эзэмшигч тус бүрийн сонгосон нэр дэвшигч бүрт 917 саналын тоогоороо тус тус саналаа өгч ТУЗ-ийн гишүүнээр сонгуулах ба үлдэх тус тусын 7 саналаа гуравдагч хувьцаа эзэмшигчийн сонгосон нэр дэвшигчид өгөх замаар түүнийг дэмжих боломжтой. Тухайн хувьцаа эзэмшигч энэхүү бутархай тоогоор илэрхийлэгдэх өөрийн саналын эрхээ зөвхөн нэг нэр дэвшигчид өгч болно.

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Үнэт цаасны зах зээлд нийт **530** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна.

Арилжаа эрхлэх 2	Төлбөр тооцооны 2	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн 1
ХОМК 25	Арилжаа эрхлэгчдийн холбоо 1	Кастодиан 3
Андерайтерийн зөвшөөрөлтэй банк 2	Хөрөнгө итгэмжлэн удирдах 4	ХК 305
ҮЦК 54	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх 1	ХАА түүхий эдийн брокер 14
ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх 60	ҮЦЗЗ-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 23	ҮЦЗЗ-д хуулийн үйлчилгээ үзүүлэх 33

*ҮЦК-д брокер, дилер, андерайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.




Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 хувиар өсөж 2.5 их наяд төгрөгт хүрсэн бол хөрвөх чадвар 1.4 пунктээр буурч 0.4 хувьд хүрлээ.
- Хөрвөх чадвар буурахад хувьцааны арилжааны хэмжээ 35.1 тэрбум төгрөгөөр буюу 4.7 дахин буурсан нь нөлөөлжээ.

Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП-20 Индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,948.6 нэгжээр буюу 18.9 хувиар буурсан.
- MSE А индекс өмнөх оны мөн үеэс 1,544.4 нэгжээр буюу 16.3 хувиар буурсан.
- MSE Б индекс өмнөх оны мөн үеэс 661.8 нэгжээр буюу 8.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. буюу 4.5 хувиар буурсан.







ХААБ-ээр нийт 28.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 4.9 тэрбум төгрөгөөр буюу 14.7 хувиар буурсан бөгөөд зөвхөн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжигджээ.



ХАА-н биржийн MAPIX индекс
 ХААБ-ээс тооцон гаргадаг Монголын хөдөө аж ахуйн индекс буюу MAPIX 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 794,438.0 нэгжид хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 291,371.5 нэгжээр буурсан байна.





1.2 ДААТГАЛЫН САЛБАР




ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

2020 оны 1 дүгээр улиралд даатгалын гүнзгийрэлт 0.44 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.01 хувиар буурсан байна.




* Давхар даатгалын зуучлагч давхардсан тоогоор орсон болно.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсөж, өмнөх улирлаас 4.3 хувиар буурч 350 тэрбум төгрөгт хүрлээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад 15.1 хувиар өсөж 286.4 тэрбум төгрөг хүрч, салбарын нийт хөрөнгийн 81.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.4 хувиар буурч, 54.1 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 15.5 хувийг эзэлж байна. 2020 оны 1 дүгээр улирлаас 1 давхар даатгалын компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор нийт хөрөнгийн өсөлт өмнөх үетэй харьцуулахад буурсан байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өсөж, 9.4 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.7 хувийг эзэлж байна.

- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж




НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 оны 1 дүгээр улиралд нийт 40.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 40.3 тэрбум төгрөг буюу 99.1 хувь, урт хугацааны даатгалын компани 0.4 тэрбум төгрөг буюу 0.9 хувийг бүрдүүлжээ.
- Нийт 13.1 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 0.8 тэрбум төгрөг буюу 5.9 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.
- 2020 оны 1 дүгээр улирлын ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.2 хувиар өсчээ.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР


- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 оны 1 дүгээр улиралд 15.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 24.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99.1 хувийг бүрдүүлжээ.
- Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 2.9 дахин өсөж 1.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.



1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


- 2020 оны 1 дүгээр улиралд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 540 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулав.
- Эдгээрийн 75 буюу 13.9 хувь нь орон нутагт, 465 буюу 86.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 5.2 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай, 94.8 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.




БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ

2020 оны 1 дүгээр улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 381.3 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар өсжээ.





Зээлийн хүү: 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.0 хувьд хүрч буурлаа.




2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 97.2 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 2.8 хувийг валютаар олгосон зээл эзлэж байна.

97.2% ₮

НИЙТ ЗЭЭЛ
2020 оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар буюу 296.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

- ХЗХ-ДЫН ТОО БА ГИШҮҮД**
- 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо 254-т хүрч өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар буурлаа.
 - ХЗХ-дын гишүүдийн тоо 2019 оны 1 дүгээр улиралд 66,296 байсан бол тайлант улиралд 12.7 хувиар өсөж 74,701-т хүрчээ.



АЖИЛЛАГСАД


810

ХЗХ-дын нийт ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.0 хувиар нэмэгдсэн бөгөөд түүний 73.1 хувь нь эмэгтэй

НИЙТ ГИШҮҮДИЙН

40,767 ЗЭЭЛДЭГЧ

38,066 ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ



- НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ**
- Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар өсөж 229.5 тэрбум төгрөгт хүрлээ.
 - Хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 23.2 пунктээр буурчээ.

НИЙТ ЗЭЭЛ
172.9 ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ХАДГАЛАМЖ
159.0 ТЭРБУМ ТӨГРӨГ

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

КОРОНАВИРУСЫН ОЙРХИ ДОРНОД БА ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Коронавирус (COVID-19) нь дэлхий даяар тархаж байгаатай холбоотойгоор Ойрхи Дорнод ба Төв Азийн бүс нутгийн өсөлт 2019 онд 1.2 хувь байснаас 2020 онд -2.8 хувь болж буурах төлөвтэй байна. Энэ нь 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал, 2015 оны газрын тосны үнийн шок зэрэг үеүдийн эдийн засгийн өсөлтийн түвшнээс доогуур байна. COVID-19 гарснаас хойш олон улсын засгийн газруудын аялал жуулчлалын хязгаарлалт нь газрын тосны эрэлтийг бууруулж, нефть экспортлогч орнуудын томоохон газрын тос үйлдвэрлэгчдийн хооронд үйлдвэрлэлийн шинэ гэрээ байгуулах боломжгүй болгосон учраас газрын тосны үнэ 50 орчим хувиар буурчээ. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн удаашралаас болж бусад бараа бүтээгдэхүүний үнэ огцом унав. Газрын тосны үнэ маш ихээр буурсан тул бүс нутгийн нефть экспортлогч бүх орнуудын төсөв, экспортын орлого буурах төлөвтэй байна. Энэ нь зарим улс орны хямралыг даван туулах бодлогыг сулруулж, валютын ханш, улсын төсөвт дарамт учруулж байна.

COVID-19 тахал нь хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахаас гадна, нэгэн зэрэг эрэлт, нийлүүлэлт цочролуудаас болж газрын тос, түүхий эдийн үнэ унах, дотоод болон гадаад эрэлт буурах, хэрэглэгчийн итгэл буурах, санхүүгийн чадамж сулрах, үйлдвэрлэл, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ тасалдах зэрэг эдийн засгийн хямралыг үүсгэж байна. Үүний зэрэгцээ бүс нутгийн засгийн газрууд хязгаарлалт тогтоож халдвар тарахаас сэргийлэх нь хэрэглэгчдийн эрэлт, ялангуяа аялал жуулчлал, амралт сувилалын газар, жижиглэн худалдааны салбарын (Азербайжан, Бахрейн, Гүрж, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улсуудын) өсөлтийг бууруулж байна. Хамгийн том нөлөөг хязгаарлагдмал нөөцөөс хамааран жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид мэдэрч байна. Түүнчлэн, үйлчилгээний салбаруудад маш их хүмүүс хөдөлмөр эрхэлдэг тул ажилгүйдэл нэмэгдэж, цалин, шилжүүлэг буурч байна.

Бүс нутгийн эдийн засгийн үйл ажиллагааны бусад хэлбэрүүд нийлүүлэлт талаас цочрол амсаж байна. Бүс нутгийн хил хязгаар хаагдсанаар нийлүүлэлтийн сүлжээ багасаж, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн тасалдаж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө буурах төлөвтэй байгаа юм. Түүнээс гадна бүс нутгийн эдийн засаг, нийгэм, геополитикийн хурцадмал байдал, тахлын дараах эдийн засгийн уналтын үргэлжлэх хугацаа сөрөг цочролууд нь бизнес эрхлэгчид болон хэрэглэгчийн итгэлийг бууруулж байна.

Хоёрдугаар сарын дунд үеэс эхлэн үнэт цаасны зах зээл 20-30 хувиар буурч, эрчим хүчний салбар хамгийн хүнд цохилтод оржээ. Олон давтамжтай тоон мэдээллээр 3-р сард бараг 5 тэрбум ам.долларын багцын урсгал бүс нутгаас гарсан болохыг харуулж байна.

Үүний зэрэгцээ, банкууд болон банк бус санхүүгийн байгууллагууд, сайн хөгжиж амжаагүй салбарууд болон байгууллагууд хямралд өртөх эрсдэлтэй байна. Түүгээр ч барахгүй өвчний дэгдэлт нь орон нутгийн засаг захиргаанд үл итгэх байдлыг нэмэгдүүлж, нийгмийн эмх замбараагүй байдлыг үүсгэж, бүс нутгийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж болзошгүй юм. Эрэлтийн мэдрэмж улам буурах нь Ойрхи Дорнод, Хойд Африк, Афганистан, Пакистан (MENAP) бүс рүү чиглэсэн хөрөнгийн урсгалыг эрс бууруулах боломжтой юм. Хөрөнгийн урсгалын гэнэтийн ийм зогсолт нь хөрөнгө оруулалтыг зогсоож, төлбөрийн үлдэгдэлд дарамт учруулж, валютын ханшийн

зохицуулалт, ялангуяа цөөн тооны нөөцтэй орнуудад нөлөөлж болзошгүй юм.

Энэхүү хүнд хэцүү нөхцөл байдлаас гарахад тухайн бүс нутгийн улс орнуудын хувьд нэн тэргүүний зорилт бол вирусын тархалтыг дарах явдал юм. Жишээлбэл, тус бүс нутгийн улс орнуудын бараг 80 хувь (25 улс) хэсэгчилсэн эсвэл бүрэн карантинд байна. Хязгаарлалтын арга хэмжээнээс гадна эрүүл мэндийн тогтолцоо нь санхүүгийн хүрэлцээтэй байдлаас үл хамааран хүн амын эрэлт хэрэгцээг хангах эрүүл мэндийн шаардлагатай зардлыг гаргах хэрэгтэй. Нэн ялангуяа бүс нутгийн эмзэг бөгөөд зөрчилдөөнд нэрвэгдсэн улс орнууд (Афганистан, Ирак, Судан, Йемен) эсвэл дүрвэгсдийн томоохон урсгалтай тулгарч буй улсууд (Иран, Иордан, Ливан, Пакистан) эрүүл мэндийн тогтолцоог COVID-19-ийн дэгдэлтэд бэлтгэх ажил нь хангамжийн бэрхшээлээс үүдэн улам хүндрэх болно. Эдгээр бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд томоохон эдийн засагтай улс орон, олон улсын байгууллагууд цаг алдалгүй эмнэлгийн болон санхүүгийн тусламж үзүүлэх шаардлагатай байгаа гэж үзэж болно. Энэ үүднээс ОУВС Йеменд өрийн хөнгөлөлтийн арга хэмжээг аль хэдийн үзүүлсэн байна.

Нэмж дурдахад, эдийн засгийн бодлогын хариу арга хэмжээг COVID-19 тахлын өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглүүлэхгүй бол тахал нь эдийн засгийг удаашруулж, ажилгүйдэл, дампуурал зэргийг нэмэгдүүлснээр нийгэмд үзүүлэх халамжийг бууруулахад хүргэж байна. Улс орнууд хүнд хэцүү салбар, ард иргэдэд зориулсан, цаг үеэ олсон, зорилтот бодлогыг ашиглаж байна. Жишээлбэл, ажилгүй хүмүүст (Казахстан) бэлэн мөнгө шилжүүлэх, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй санхүүжилт олгох (Саудын Араб) гэх зэрэг.

Төсөв хязгаарлагдмал байгаа бусад орнуудад, ялангуяа бүс нутгийн нефть импортлогч орнуудын засгийн газар зардлын тэргүүлэх чиглэлийг өөрчлөх хэрэгтэй байна. Жишээлбэл, чухал бус зардлыг бууруулах, хойшлуулах, гадаад санхүүжилтийн дэмжлэг эсвэл туслалцаа авах зэрэг асуудлыг шийдэж болно. ОУВС нь Иордан, Киргизстан, Пакистан, Тунис улсуудад санхүүгийн дэмжлэг үзүүлж, олон улсын зээлдүүлэгчдээс Сомалид төлөх өр төлбөрөөс ангижруулж, улс орон бүрт тахлын эсрэг тэмцэхэд нэмэлт бодлогыг хэрэгжүүлж байна. Нэмэлт санхүүгийн бүлгэмийн орнуудад нэмэлт санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд ОУВС нь бүх гишүүн орнуудад бодлогын дэмжлэг үзүүлсээр байгаа юм.

Улс орнуудын төв банк нь банкууд болон банк бус санхүүгийн байгууллагууд, тэр дундаа ЖДҮ эрхлэгчдэд зээл олгох, тэдгээрийн хөрвөх чадварыг хангахад бэлэн байх ёстой. Санхүүгийн зах зээлийн зохицуулагч, хянагч нар зээлийн гүйцэтгэл, түүнтэй холбоотой санхүүгийн үр дагаврыг тогтмол үнэлэх замаар зээлийн хугацааг түр сунгахад дэмжлэг үзүүлэх боломжтой юм. 4-р сарын байдлаар бүсийн долоон төв банк, түүний дотор Бахрейн, Марокко, АНЭУ зэрэг улсуудын банкууд COVID-19-тэй тэмцэх үеэр хөрвөх чадварыг дэмжих зорилгоор 50 тэрбум орчим ам.долларыг өөрийн санхүүгийн системд оруулжээ.

Гадаад эрэлт суларч, санхүүгийн байдал хүндэрвэл улс орнууд гадаад бэрхшээлтэй тулгарах болно. Уян хатан ханштай, инфляци багатай улсууд валютын ханшийн тохируулгад цочролыг шингээх боломжийг хайх хэрэгтэй. Мөн хөрөнгийн гадагшлах урсгал болон валютын ханшийн урсгалын инфляцид үзүүлэх нөлөөллийг агуулсан байхын тулд мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

УЛС ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


	2019	2020	2021 (Төсөөлөл)
ДНБ-ий бодит өсөлт (Жилийн өөрчлөлт; хувиар)	4.8	-1.0	4.7
Армени	7.6	-1.5	4.8
Азербайжан	2.3	-2.2	0.7
Гүрж	5.1	-4.0	3.0
Казахстан	4.5	-2.5	4.1
Киргиз	4.5	-4.0	8.0
Тажикистан	7.5	1.0	5.5
Туркменистан	6.3	1.8	6.4
Узбекистан	5.6	1.8	7.0
Хэрэглээний үнийн индекс (Жилийн дундаж; хувь)	6.8	7.7	6.9
Армени	1.4	0.8	2.0
Азербайжан	2.6	3.3	3.2
Гүрж	4.9	4.6	3.7
Казахстан	5.2	6.9	6.8
Киргиз	1.1	10.6	7.2
Тажикистан	7.8	8.1	6.9
Туркменистан	5.1	8.0	6.0
Узбекистан	14.5	12.6	10.6
Засгийн газрын төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувиар)	0.6	-5.6	-3.1
Армени	-1.0	-5.0	-2.5
Азербайжан	8.4	-12.8	-9.7
Гүрж	-2.0	-7.8	-3.8
Казахстан	-0.6	-5.3	-2.7
Киргиз	-0.1	-9.6	-6.4
Тажикистан	-2.1	-6.4	-3.0
Туркменистан	-0.3	-2.3	-0.5
Узбекистан	0.0	-3.3	-1.3
Дансны үлдэгдэл (ДНБ-д эзлэх хувиар)	-1.6	-7.2	-5.0
Армени	-8.2	-8.6	-7.2
Азербайжан	9.2	-8.2	-3.7
Гүрж	-5.1	-10.5	-6.9
Казахстан	-3.6	-6.8	-5.5
Киргиз	-9.1	-16.6	-11.0
Тажикистан	-3.3	-7.7	-4.5
Туркменистан	5.1	-1.4	-0.4
Узбекистан	-5.6	-9.4	-6.4

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр


S&P 500 /^GSPC/

2,991.77 +36.32 (+1.23%)




Nikkei 225 /^N225/

21,446.22 +175.05 (+0.82%)



FTSE 100 /^FTSE/

6,067.76 +74.48 (+1.24%)



Dubai Financial Market General Index DFMGI:IND

1,938.91 +5.42 /+0.28%/



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160

+976-51-264444

press@frc.mn

www.frc.mn

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC_of_Mongolia